



ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот,
2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ	4
ХОЁР. ТТБЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ	5
2.1.Зөвлөлийн бүрэлдэхүүн	5
2.2.ТТБЗ-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэл	5
2.2.1.2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс өмнө мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу хүлээсэн Зөвлөлийн үндсэн чиг үүрэг	5
2.2.2.Зөвлөлд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр шинээр нэмэгдсэн чиг үүрэг	5
2.2.3.Эрх зүйн шинэчлэлийн ач холбогдол	6
ГУРАВ. ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ	7
3.1.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал (2026–2028)	7
3.2.Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт.....	8
3.3.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (2026–2028)-д өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт	9
3.4.Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаар ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт	10
3.5.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн дүгнэлт	11
3.6.2025–2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт	12
3.7.Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төсөлд өгсөн дүгнэлт.....	13
3.8.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах асуудлаарх байр суурь	14
3.9.Төсвийн төслийг боловсруулах явц дахь 2026 оны төсвийн хязгаар ба олон нийтийн оролцооны талаар өгсөн дүгнэлт	15
3.10.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт.....	16
3.11.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	16
3.12.Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас 2026–2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах талаар гаргасан саналд өгсөн дүгнэлт	17
3.13.Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад гаргасан саналуудын талаарх дүгнэлт	18
3.14.Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийн талаарх санал.....	19
3.15.“Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн санал.....	21
3.16.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн орчны талаарх санал.....	22
ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА	23
4.1.Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг.....	23
4.2.Төсвийн төслийн боловсруулалтын шатны хэлэлцүүлэг	23
4.3.Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлэг	24
4.4.БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албатай хамтран ажилласан нь	25
4.5.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	26
4.6.Олон Улсын Валютын Сантай хамтран ажилласан байдал	28

4.7.УИХ-тай хамтран ажилласан байдал.....	29
4.8.УИХ-ын чуулганы хуралдаан, хэлэлцүүлэгт оролцсон байдал.....	30
4.9.Засгийн газар болон бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	30
ТАВ. ДОТООД АЖИЛ	32
5.1.ТТБЗ-ийн үйл ажиллагааны журам.....	32
5.2.ТТБЗ-ийг институтийн хувьд бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	33
5.3.Судалгаа, эрдэм шинжилгээний ажил	34
ЗУРГАА. ХАВСРАЛТ.....	37

НЭГ. УДИРТГАЛ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (цаашид ТТБЗ гэх) нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд улсын төсөв, төсвийн бодлогын тогтвортой байдлыг хангах, төсвийн сахилга бат, ил тод байдал, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, мөн дунд хугацааны төсвийн бодлогын зорилтыг хангах чиглэлээр хараат бус дүн шинжилгээ хийж, УИХ болон Засгийн газарт дүгнэлт, зөвлөмж хүргүүлэн ажилладаг.

Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ улсын төсөв, дунд хугацааны төсвийн баримт бичгүүд, хөгжлийн бодлогын баримт бичиг, төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн тайлан зэрэг төсөв, санхүүгийн бодлогын үндсэн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан УИХ болон холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан. Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмж нь төсвийн бодлогын үндсэн шалгуур үзүүлэлтүүд, төсвийн тэнцэл, орлого бүрдүүлэлт, зарлагын бүтэц, төсвийн сахилга бат, өрийн тогтвортой байдал, төсвийн эрсдэлийн үнэлгээ зэрэг асуудлыг хамарч, төсвийн бодлого, төлөвлөлтийг илүү бодитой, үндэслэлтэй болгоход чиглэсэн.

Зөвлөлөөс 2025 онд боловсруулж хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжүүд нь төсвийн бодлогын хэлэлцүүлгийн явцад олон талын оролцоог хангах, төсвийн төсөл болон дунд хугацааны төсвийн баримт бичгүүдийг илүү нотолгоонд суурилан үндэслэлтэй хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд төсвийн төсөл, тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, бодлогын зорилт, санхүүжилтийн боломж, хэрэгжилтийн бодит чадавхыг зэрэгцүүлэн үнэлэх шаардлагыг онцлон анхааруулж ажилласан.

Мөн Зөвлөл нь төсвийн тогтвортой байдлыг хангахад сөргөөр нөлөөлөх боломжит эрсдэлүүдийг тодорхойлох, тэдгээрийн төсөв, эдийн засгийн орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх чиглэлээр ажиллаж, төсвийн орлого бүрдүүлэлт, экспортын нөхцөл, үнийн хэлбэлзэл, зардлын дарамт, хөрөнгө оруулалтын хэрэгжилт, өрийн үйлчилгээний төлбөр, төсвийн хариуцлагын хэрэгжилт зэрэг хүчин зүйлсийг авч үзэн дүгнэлт гаргасан. Энэ хүрээнд төсвийн бодлогын хэрэгжилтийг дунд хугацаанд тогтвортой байлгахын тулд төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагын тогтолцоог бодитой хэрэгжүүлэх шаардлагатайг Зөвлөлөөс тогтмол онцолсон.

Түүнчлэн Зөвлөл нь УИХ, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагууд, олон улсын байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах уулзалт, хэлэлцүүлгүүдэд оролцож, төсвийн бодлогын орчин, дунд хугацааны төлөвлөлт, төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсвийн эрсдэлийн удирдлагатай холбоотой асуудлаар санал солилцож ажилласан нь бодлогын уялдаа холбоог сайжруулах, төсвийн бодлогын хэлэлцүүлгийг өргөжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан.

Энэхүү тайланд ТТБЗ-өөс 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, боловсруулсан дүгнэлт, зөвлөмж, олон нийттэй харилцах үйл ажиллагаа, хамтын ажиллагаатай холбоотой ажлууд, мөн цаашид анхаарах асуудлуудыг нэгтгэн тусгасан болно.

ХОЁР. ТТБЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1.Зөвлөлийн бүрэлдэхүүн

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.3-д заасны дагуу ТТБЗ нь орон тооны долоон гишүүнээс бүрдэх бөгөөд УИХ-ын Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулж, УИХ-аас 4 жилийн хугацаатай 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр томилогдон хоёр дахь жилдээ ажиллаж байна. УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 645 дугаар захирамжаар УИХ-ын Тамгын газрын бүтцэд өөрчлөлт орсноор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.17-д заасны дагуу ТТБЗ нь Ажлын албатай болсон.

2.2.ТТБЗ-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний шинэчлэл

ТТБЗ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн баталсан бусад хууль, эрх зүйн актад үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг хараат бус, мэргэжлийн байгууллага юм.

Зөвлөлийн үндсэн зорилго нь улсын төсөв, санхүүгийн бодлогын тогтвортой байдал, сахилга батыг хангахад парламентын хяналтыг бэхжүүлэх, төсвийн бодлогын шийдвэрүүдийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг мэргэжлийн үүднээс, хараат бусаар үнэлэхэд оршино.

2.2.1.2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс өмнө мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу хүлээсэн Зөвлөлийн үндсэн чиг үүрэг

Зөвлөл нь 2025 оноос өмнө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5 дахь хэсэгт заасны дагуу дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)-ийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах;
- Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл нь хуульд заасан шалгуурыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд дүгнэлт гаргах;
- УИХ-ын Төсвийн байнгын хорооны чиглэлийн дагуу төсөвтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн төсөвт үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ хийх, зөвлөмж гаргах;
- Төсвийн баримт бичгийг олон нийтээр хэлэлцүүлэх үйл ажиллагаанд оролцож, мэргэжлийн байр суурь илэрхийлэх чиг үүрэг хамаарч байв.

2.2.2.Зөвлөлд 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр шинээр нэмэгдсэн чиг үүрэг

2025 оны 07 дугаар сараас эхлэн төсвийн бодлогод тавих УИХ-ын хяналтыг бэхжүүлэх зорилгоор Зөвлөлийн чиг үүрэг, оролцооны цар хүрээ мэдэгдэхүйц өргөжсөн. Үүнд:

Төсвийн боловсруулалтын бүх үе шатанд хяналт тавих чиг үүрэг

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Зөвлөл нь:

- Төсвийн төслийн боловсруулалтын үе шатанд:
 - төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн урсгал болон хөрөнгийн зардлын хэмжээ нь хуульд заасан төсвийн хязгаарт нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийх;
 - төсвийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, түүний үр дүнг төсөвт тусгасан эсэхэд хяналт тавих;
- Дээрх асуудлаар гаргасан шинжилгээ, танилцуулга, саналыг УИХ-д төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнө Төсвийн байнгын хороо, Сангийн яаманд хүргүүлэх шинэ үүрэг хүлээсэн.

Төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд оролцох үүрэг

Зөвлөл нь 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн:

- Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд
 - төсвийн төсөл нь Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэхэд дүгнэлт гаргах;
- Шаардлагатай тохиолдолд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Төсвийн байнгын хороог тооцоо, мэдээллээр хангаж ажиллах шууд оролцооны чиг үүрэгтэй болсон.

Төсвийн хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийх үүрэг

Шинэ зохицуулалтын хүрээнд Зөвлөл нь:

- Хагас жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд ажлын 14 өдрийн дотор дүн шинжилгээ хийж, дүгнэлт, саналын хамт УИХ-ын гишүүд, холбогдох Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд тус тус хүргүүлэх;

Ингэснээр Зөвлөл нь төсвийн хэрэгжилтийн явцад тасралтгүй, бодит цагийн хяналтын үүрэг гүйцэтгэх эрх зүйн боломж бүрдсэн.

2.2.3. Эрх зүйн шинэчлэлийн ач холбогдол

ТТБЗ нь 2025 онд хэрэгжиж эхэлсэн эдгээр өөрчлөлтийн үр дүнд зөвхөн дүгнэлт гаргахаас гадна төсвийн боловсруулалт, хэлэлцүүлэг, хэрэгжилт гэсэн төсвийн бүх үе шатанд оролцдог, УИХ-ын мэргэжлийн, хараат бус хяналтын институт болон бэхжих эрх зүйн орчин бүрдсэн.

ГУРАВ. ЗӨВЛӨЛ ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙНХЭЭ ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

3.1.Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал (2026–2028)

ТТБЗ нь Төсвийн тухай хуулийн 8.1.2, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.1-д заасны дагуу Монгол Улсын 2026–2028 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тайланг боловсруулж, 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.

Макро эдийн засгийн таамаглалыг боловсруулахдаа гадаад, дотоод эдийн засгийн орчны шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, мөн олон улсын байгууллагуудын ашигладаг тоон загварын аргачлалд тулгуурласан болно. Тухайлбал, байгалийн баялагт суурилсан эдийн засагтай улс орнуудад тохиромжтой DIGNAR (Debt, Investment, Growth, and Natural Resources) динамик статистик ерөнхий тэнцвэрийн загвар, мөн бодит, мөнгөний, сангийн болон гадаад секторын уялдааг хамарсан САЕМ (Comprehensive Adaptive Expectations Model) загварыг суурь болгон ашигласан.

Гадаад орчны шинжилгээнээс харахад АНУ-БНХАУ хоорондын худалдааны зөрчил, геополитикийн хурцадмал байдал, дэлхийн түүхий эдийн зах зээлийн хэлбэлзэл нь Монгол Улсын эдийн засагт эрсдэлийн гол хүчин зүйл хэвээр байна. Ялангуяа БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл, нүүрсний импортын бодлого, үнэ ханш буурах хандлага нь Монгол Улсын нүүрсний экспортын орлого, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх магадлалтай байгааг Зөвлөл дүгнэж, онцолсон.

Дотоод эдийн засгийн нөхцөл байдлын хувьд сүүлийн жилүүдэд эдийн засгийн огцом тэлэлт ажиглагдсан боловч үүнийг дагасан төсвийн тэлэлт, орлогын мөчлөг дагасан савлагаа, уул уурхайн орлогоос хэт хамаарах байдал нь дунд хугацаанд төсвийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүйг дүгнэсэн. Иймд Зөвлөл нь эдийн засгийн таатай нөхцөл үргэлжилнэ гэсэн өөдрөг хандлагаас зайлсхийж, болгоомжтой, нэг хувилбартай таамаглал боловсруулах нь зүйтэй гэж үзсэн.

Зөвлөлийн боловсруулсан таамаглалаар 2026-2028 онд ДНБ-ий бодит өсөлт 5.4-5.7 хувь, инфляц аажмаар саарч 8.2 хувиас 6.8 хувь хүртэл буурах, ДНБ-д Засгийн газрын өрийн эзлэх хувь 37.5 хувиас 36.3 хувь хүртэл буурах хандлагатай байхаар тооцоолсон. Гэсэн ч экспортын орлогын гол эх үүсвэр болох нүүрсний үнэ, биет хэмжээний таамаглалд гадаад зах зээлийн тодорхойгүй байдал нөлөөлөх эрсдэл өндөр хэвээр байгааг анхааруулсан болно. Иймд Зөвлөлийн зүгээс дунд хугацаанд төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хадгалах, орлогын өсөлтийг дагасан зардлын огцом тэлэлтээс зайлсхийх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого баримтлахыг зөвлөсөн бөгөөд энэхүү макро эдийн засгийн таамаглал нь төсвийн бодлогын шийдвэр гаргахад суурь баримт бичиг болох ач холбогдолтой юм. 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр ТТБЗ-өөс “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал” сэдвээр хэвлэлийн бага хурал зохион байгуулж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашигласан макро эдийн засгийн таамаглалын талаар олон нийтэд дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Хэвлэлийн бага хуралд хэвлэл мэдээллийн 20 байгууллага оролцож, эдийн засгийн өсөлт, инфляцын төлөв, гадаад орчны эрсдэл, уул уурхайн салбарын нөлөөлөл, төсвийн тогтвортой байдалд үзүүлэх үр дагаврын талаар асуулт асууж, Зөвлөлийн зүгээс холбогдох тайлбар, байр суурийг тодорхой илэрхийлсэн.



Энэхүү хэвлэлийн бага хурал нь Зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал, макро эдийн засгийн бодлогын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, төсвийн бодлогын суурь таамаглалын талаар мэргэжлийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нээлттэй харилцах чухал ач холбогдолтой үйл ажиллагаа болсон.

3.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төслийг холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан шинжилж, макро эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын уялдаа, санхүүжилтийн боломж, хэрэгжилтийн бодит нөхцөлийг харгалзан дүгнэлтээ боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д хүргүүлсэн.

Шинжилгээгээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал таатай үеэс саарах шат руу шилжиж болзошгүй байгааг харуулж байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт уул уурхайн салбар, ялангуяа түүхий эдийн экспортод түшиглэн тэлсэн боловч гадаад орчны тодорхойгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, дотоодын бүтцийн эмзэг байдал зэргээс шалтгаалан макро эдийн засгийн эрсдэл нэмэгдэж байна. Энэ нөхцөлд хөгжлийн бодлого, жилийн төлөвлөгөөг хэт өөдрөг таамаглалд тулгуурлан боловсруулах нь төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзэв.

Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө нь зорилгын хувьд урт болон дунд хугацааны хөгжлийн бодлоготой ерөнхийдөө уялдаатай боловч гүйцэтгэлийн түвшинд буюу шалгуур үзүүлэлт, мониторинг, хяналт-шинжилгээний хувьд уялдаа хангалтгүй. Олон зорилт, арга хэмжээ нь хэмжигдэхүйц, үнэлэгдэхүйц (SMART) шалгуургүй, суурь болон зорилтот түвшин тодорхой бус байгаа нь хэрэгжилтийг бодитой үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн бүтэц нь бодитой хэрэгжих боломжийн талаас эрсдэлтэй байгааг ТТБЗ онцолсон.

Нийт санхүүжилтийн дүн өндөр, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төсөл, арга хэмжээ цөөнгүй байгаа нь төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байсан. Түүнчлэн төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад зээл, хөрөнгө оруулалтад хэт өндөр хүлээлт тавьсан нь санхүүгийн эрсдэлийг нэмэгдүүлэх магадлалтай. Томоохон мега төслүүдийн хувьд зарим төсөлд нийт өртөг, хэрэгжих хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр, үр ашгийн тооцоо тодорхой бус, эсхүл жилийн төлөвлөгөөнд зорилт, үр дүнгийн шалгуургүйгээр тусгагдсан тохиолдол байгааг дүгнэв. Ийм нөхцөлд эдгээр төслийг

товлосон хугацаанд хэрэгжүүлэх, төсвийн тогтвортой байдалд сөрөг дарамт үүсгэхгүй байх боломж эргэлзээтэй гэж үзсэн юм.

Иймд ТТБЗ-өөс Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх явцад бодлогын баримт бичгүүдийн уялдаа, залгамж чанарыг сайжруулах, санхүүжилтийн бодит эх үүсвэр, төсвийн чадавхтай нийцүүлэх, төсөл, арга хэмжээг эрэмбэлэх, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, макро эдийн засгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

3.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (2026–2028)-д өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт

ТТБЗ-өөс Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн төслийг холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн өнөөгийн болон дунд хугацааны нөхцөл байдалтай уялдуулан шинжилж, бодлогын чиг хандлага, эрсдэл, хэрэгжих боломжийн талаарх дүгнэлтийг боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр УИХ-д хүргүүлсэн. Шинжилгээгээр дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого нь эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, төсвийн зарлагын тэлэлтийг хязгаарлах, төсвийн сахилга батыг сайжруулахад чиглэсэн нь сүүлийн жилүүдэд огцом тэлсэн төсвийн бодлогын эрсдэлийг бууруулахад нийцтэй зөв чиглэл гэж үнэлэгдэж байна.

Нэгдсэн төсвийн нийт болон урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулж, дунд хугацаанд төсвийг алдагдалгүй байхаар төлөвлөсөн нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих ач холбогдолтой. Гэсэн ч макро эдийн засгийн таамаглал, ялангуяа суурь оны эдийн засгийн өсөлтийг өндөр түвшинд төсөөлсөн байдал, уул уурхайн салбар болон нэр бүхий томоохон төслүүдийн хэрэгжилтэд ихээхэн найдсан хандлага нь төсвийн орлого, зарлагын бодит хэрэгжилтэд эрсдэл үүсгэж болзошгүй байна. 2026-2028 оны эдийн засгийн өсөлт, экспорт, зарим эрдсийн бүтээгдэхүүний биет хэмжээ, үнийн таамаглал нь бодит нөхцөл байдлаас хэт өөдрөг байж болзошгүй тул төлөвлөлтийн бодитой байдлыг хангах шаардлагатай гэж дүгнэсэн.

Төсвийн орлого өмнөх жилүүдтэй харьцуулахад хэт өөдрөг төсөөллөөс тодорхой хэмжээнд татгалзсан, тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувийг бууруулахаар төлөвлөсөн нь эрсдэлийг бууруулах эерэг өөрчлөлт гэж үзэж байна. Гэвч тэнцвэржүүлсэн үнийг тооцох аргачлал нь төсвийн орлогыг бодитоос өндөр гаргах нөлөөтэй хэвээр байгаа тул цаашид орлогын төлөвлөлтийг илүү бодитой болгох шаардлагатай.

Төсвийн зарлагын бодлогын тухайд ДНБ-д төсвийн урсгал зардлын эзлэх хувийг дунд хугацаанд мэдэгдэхүйц бууруулахаар төлөвлөсөн, төрийн үр ашиггүй зардлыг хязгаарлах, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, төрийн оролцоог багасгах зорилтууд дэвшүүлсэн нь төсвийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Гэхдээ инфляц өндөр хэвээр байгаа нөхцөлд цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай шууд уялдуулан нэмэх бодлогын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг анхаарч, зохистой түвшинд хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын хувьд ДНБ-д эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхээс илүүтэйгээр хөгжлийн бодлого, тэргүүлэх зорилттой уялдуулсан оновчтой хуваарилалт хийх, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн төсвийн хүрээнд ил тод, нэгдмэл байдлаар төлөвлөх шаардлагатай гэж үзсэн. Салбар хоорондын хөрөнгө оруулалтын тэнцвэр, ялангуяа дэд

бүтэц, эрчим хүч зэрэг суурь салбаруудад чиглэсэн хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлогод нийцүүлэх нь чухал байна.

Өрийн удирдлагын хувьд Засгийн газрын өрийн ачаалал буурч байгаа эерэг хандлагыг хадгалах шаардлагатай боловч өрийн удирдлагын стратегид зөвхөн Засгийн газрын өрөөс гадна төрийн өмчит байгууллагууд, Монголбанкны болон болзошгүй өр төлбөр зэрэг нийт эдийн засагт нөлөөлөх өрийн асуудлыг цогцоор нь хамруулах шаардлагатай. Түүнчлэн дунд хугацааны өрийн стратегийн суурь тооцоолол нь төсвийн хүрээний мэдэгдэлтэй бүрэн нийцэж байх нь зүйтэй гэж үзсэн.

Ерөнхийд нь авч үзвэл дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын чиглэл сайжирч, төсвийн тэлэлтийг хязгаарлах, төрийн оролцоог бууруулах, төсвийн сахилга батыг бэхжүүлэх зорилтууд дэвшүүлсэн нь зөв боловч эдгээр бодлогын хэрэгжилтийг хангах, макро эдийн засгийн таамаглалыг бодит нөхцөл байдалд нийцүүлэх, орлого, зарлагын төлөвлөлтийн эрсдэлийг бууруулахад онцгой анхаарах шаардлагатай гэж ТТБЗ дүгнэсэн.

3.4. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаар ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт

ТТБЗ-өөс Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, макро эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогын чиглэл, төсвийн сахилга бат, үр ашиг, тогтвортой байдлын хүрээнд цогцоор нь шинжилж дүгнэлт гарган 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр УИХ-д хүргүүлэв. Шинжилгээгээр 2024 оны төсвийн гүйцэтгэл нь эдийн засгийн таатай мөчлөгийн нөлөөгөөр орлого, зарлага өндөр түвшинд хүрсэн хэдий ч төсвийн бодлогод мөчлөг сөрсөн зарчмыг хангалттай баримтлаагүй нь төсвийн тэлэлтийг нэмэгдүүлж, эдийн засаг дахь төрийн оролцоог огцом өсгөсөн гэж үзсэн. Төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээний ДНБ-д эзлэх хувь мэдэгдэхүйц өссөн нь богино хугацаанд төсвийн боломжийг нэмэгдүүлсэн боловч дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдалд дарамт учруулах эрсдэлтэй байсан.

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан 2024 оны Төсвийн тодотголтой хамт төсвийн тусгай шаардлагад өөрчлөлт оруулж, төсвийн зарлагыг огцом нэмэгдүүлсэн нь төсвийн сахилга бат, хууль тогтоомжийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн гэж Зөвлөл дүгнэв. Хэдийгээр төсвийн тусгай шаардлагын үзүүлэлтүүд гүйцэтгэлээрээ хангагдсан хэдий ч энэ нь эдийн засгийн таатай нөхцөл, мөчлөгийн нөлөөгөөр бий болсон үр дүн бөгөөд төсвийн бодлогын дотоод сахилга бат сайжирсны илрэл гэж үзэх боломж хязгаарлагдмал юм.

Төсвийн гүйцэтгэлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баримтлах байдал хангалтгүй хэвээр байгааг Зөвлөл онцолсон. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь тухайн жилийн төсвийн төлөвлөлтийн суурь баримт бичиг байх ёстой боловч бодит байдалд төсвийг даган өөрчлөгдөж, түүний үндсэн үзүүлэлтүүд удаа дараа шинэчлэгдэж ирсэн нь төсвийн бодлогын залгамж чанар, бодитой төлөвлөлтийг алдагдуулж байна.

Төсвийн бодлогын эдийн засаг, нийгмийн үр нөлөөг үнэлэх тогтолцоо сул хэвээр байгаа нь анхаарах асуудал хэвээр төдийгүй төсвийн зарлагын огцом өсөлт нь эдийн засгийн өсөлтийг хангалттай дэмжиж чадаагүй бөгөөд төсвийн бодлого бодит эдийн засагт ямар үр ашиг, нөлөө үзүүлж байгааг хэмжих тодорхой шалгуур, үнэлгээний тогтолцоо бүрдээгүй байна. Иймд төсвийн гүйцэтгэлийг зөвхөн тоон биелэлтээр бус, бодлогын үр нөлөөгөөр үнэлэх, төсвийн нэгдмэл байдлыг хангах асуудалд онцгой анхаарах шаардлагатай гэж дүгнэв.

Нэгдсэн төсвийн хүрээнд хэлэлцэж, дүгнэлт гаргаж байгаа хэдий ч бодит байдалд улсын болон орон нутгийн төсвийн гүйцэтгэл зөрүүтэй тайлагнагдаж, нэгдсэн төсвийн нийт үзүүлэлтүүдэд өөрчлөлт орох нөхцөл байдал давтагдаж байна. Энэ нь төсвийн нэгдмэл бодлогын хэрэгжилтэд эрсдэл үүсгэж болзошгүйг харуулж байгаа юм.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл төлөвлөсөн түвшинд хүрээгүй, ялангуяа шинэ хөрөнгө оруулалтын төслүүдийн гүйцэтгэл бага хэвээр байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн чанарт асуудал байгааг илтгэнэ. Төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлоготой уялдуулахгүйгээр төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, төсвийн нөөцийг оновчгүй хуваарилах эрсдэлийг нэмэгдүүлсэн гэж үзэв.

Ерөнхийд нь дүгнэхэд, 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь хуульд заасан зарим шалгуурыг хангаж байгаа хэдий ч төсвийн бодлогын мөчлөг сөрөх зарчим, дунд хугацааны төлөвлөлтийн сахилга бат, бодлогын үр нөлөөний үнэлгээ, төсвийн нэгдмэл байдал, хөрөнгө оруулалтын үр ашиг зэрэг чиглэлээр цаашид бодлогын томоохон шинэчлэл, сайжруулалт хийх шаардлагатай байгааг Зөвлөл онцолсон.

3.5. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн дүгнэлт

Зөвлөл нь Монгол Улсын Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох тайлан, тогтоолын төслийг үндэслэн дүгнэлт гарган 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр УИХ-д хүргүүлсэн. Шинжилгээгээр 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан Засгийн газрын нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгийн хэмжээ өмнөх жилүүдээс мэдэгдэхүйц өссөн нь эдийн засгийн таатай мөчлөг, орлогын өсөлттэй уялдсан хэдий ч эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлэх хандлага давамгайлж байгааг харуулсан. Төрийн болон төсвийн байгууллага, төсөл, сангийн тоо өссөн нь урсгал зардал нэмэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлж, дунд хугацаанд төсвийн тогтвортой байдалд дарамт учруулах эрсдэлтэй гэж үзэв.

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаас харахад нийт хөрөнгийн бүтцэд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь өсөж, эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь буурч байгаа нь богино хугацаанд санхүүгийн уян хатан байдал нэмэгдэж буйг илтгэх боловч нөгөө талаас хөрөнгийн бүтцийн оновч, ашиглалтын үр ашгийг сайжруулах шаардлага байгааг харуулж байна. Харин өр төлбөрийн дүн нэмэгдсэн хэдий ч нийт хөрөнгөд эзлэх өрийн харьцаа буурч, цэвэр хөрөнгийн эзлэх хувь өссөн нь зохистой эерэг хандлага гэж дүгнэв.

Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар 2024 онд үйл ажиллагааны нийт үр дүн эерэг гарсан нь татварын болон татварын бус орлого, үйл ажиллагааны бус орлого нэмэгдсэнтэй холбоотой боловч орлогын бүтцэд нийтлэг бус татварын орлогын эзлэх хувь өндөр байгаа нь орлогын тогтвортой байдалд эрсдэл үүсгэж болзошгүй байна. Түүнчлэн үйл ажиллагааны зардлын дийлэнхийг урсгал зардал эзэлж, түүний дотор цалин хөлс, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлын эзлэх хувь өссөн нь төсвийн зардлын бүтцийг илүү оновчтой болгох шаардлагатайг харуулж байна.

Мөнгөн хөрөнгийн удирдлагын хувьд төрийн болон төсвийн байгууллагууд, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн арилжааны банканд байршиж буй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өндөр түвшинд хүрсэн байхад Засгийн газар богино хугацааны үнэт цаас гарган санхүүжилт татаж, хүүгийн зардал төлсөн нь мөнгөн хөрөнгийн удирдлага хангалтгүй байгааг илтгэнэ.

Иймд төрийн мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах, Төрийн сангийн нэгдсэн удирдлагыг бодитой хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

Аудитын дүгнэлтээс харахад төсөв, санхүүгийн сахилга баттай холбоотой зөрчил, алдаа өмнөх оноос огцом өссөн нь төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт сул, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгааг харуулна. Төсвийн байгууллагууд, төрийн өмчит хуулийн этгээдүүдийн авлага, өглөгийн хэмжээ өндөр хэвээр байгаа нь санхүүгийн удирдлагын сул талыг илтгэж, төсвийн нөөцийг үр ашиггүй ашиглах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Нэгтгэн үзвэл, 2024 оны Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь тоон үзүүлэлтийн хувьд сайжирсан талтай боловч төсвийн сахилга бат, төрийн байгууллагын бүтэц, зардлын үр ашиг, мөнгөн хөрөнгийн удирдлага, аудитын дүгнэлтээр илэрсэн зөрчлийг арилгах чиглэлээр бодлогын цогц шинэчлэл, хариуцлагын тогтолцоог чангатгах шаардлага хэвээр байгааг Зөвлөл дүгнэсэн.

3.6.2025–2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт

Зөвлөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026–2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүгнэлт гарган 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д хүргүүлсэн.

Шинжилгээгээр төсвийн бодлогын ерөнхий чиглэл өмнөх жилүүдтэй харьцуулахад бодит эдийн засгийн нөхцөл байдалд илүү нийцэх хандлагатай болж, төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулах, эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах зорилт дэвшүүлсэн нь зүйтэй хандлага гэж үнэлэв. Өргөн барьсан өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн орлого, зарлагын харьцааг дунд хугацаанд аажмаар бууруулахаар төлөвлөсөн нь өнгөрсөн хугацаанд хэт тэлсэн төсвийн бодлогын эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулахад чиглэж байсан. Гэсэн ч макро эдийн засгийн зарим үндсэн үзүүлэлт, ялангуяа эдийн засгийн өсөлт, нэрлэсэн ДНБ, инфляцын таамаглал нь бодит нөхцөл байдалтай бүрэн нийцэх эсэх нь эргэлзээтэй хэвээр байгааг Зөвлөл онцолсон юм. Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах шалтгааны нэг нь төсвийн орлогын анхны өөдрөг төсөөлөл бодит байдалтай зөрсөн явдал бөгөөд энэ нь орлогын төлөвлөлтийг цаашид илүү болгоомжтой, үндэслэлтэй хийх шаардлагатайг харуулна.

Төсвийн зарлагын хэмжээг бууруулах шийдвэр нь эдийн засгийн өсөлтөд ямар нөлөө үзүүлэх, төсвийн зарлагын таналт эдийн засгийн бусад салбарт ямар дам нөлөө үзүүлэх талаар нарийвчилсан тооцоо, үнэлгээ хангалттай тусгагдаагүй байгааг анхаарах шаардлагатай гэж дүгнэв. Төсөв төвтэй эдийн засгийн бүтэц бүрдсэн нөхцөлд төсвийн огцом таналт нь эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул үе шаттай, нөлөөллийг тооцсон бодлого баримтлах нь зүйтэй. Мөн голлох эрдэс баялгийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг зах зээлийн бодит нөхцөлөөс өндөр түвшинд тооцож байгаа нь төсвийн орлогыг бодит байдлаас өндрөөр төлөвлөх эрсдэл үүсгэж буйг Зөвлөл онцолсон. Тэнцвэржүүлсэн үнийг тооцох аргачлалыг олон улсын болон Монгол Улсын экспортын бодит зах зээлийн нөхцөлд илүү нийцүүлэх шаардлагатай гэж үзсэн юм.

Нэг удаагийн төсвийн тодотголыг дагуулж дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараалан өөрчлөлт оруулж байгаа нь төсвийн бодлогын тогтвортой байдал, залгамж

чанарыг алдагдуулж, дунд хугацааны төлөвлөлтийн ач холбогдлыг сулруулж байгааг анхааруулсан. Цаашид дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, хатуу болгох шаардлагатай гэж үзсэн болно.

Ерөнхийд нь авч үзвэл, 2025-2028 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд оруулсан өөрчлөлт нь төсвийн тэлэлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах чиглэлд тодорхой ахиц гаргасан боловч макро эдийн засгийн таамаглалын бодитой байдал, орлогын төлөвлөлтийн эрсдэл, төсвийн хүрээний мэдэгдлийн тогтвортой байдал, зарлагын өөрчлөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг илүү нарийвчлан тооцох шаардлага хэвээр байна гэж дүгнэсэн.

3.7. Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголын төсөлд өгсөн дүгнэлт

Зөвлөл нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буюу төсвийн тодотголын төслийг холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлын хүрээнд шинжилж дүгнэлт гаргаж 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр УИХ-д хүргүүлсэн.

Шинжилгээгээр 2025 оны төсвийн тодотгол хийх болсон гол шалтгаан нь экспортын орлогын тасалдал, ялангуяа нүүрсний үнийн огцом бууралт, эдийн засгийн өсөлтийн сааралттай шууд холбоотой гэж үзэв. Гэвч уг нөхцөл байдал нь урьдчилан тооцоолох боломжгүй гэнэтийн хүчин зүйл бус, харин өмнөх жилүүдээс ажиглагдаж байсан хандлагын үргэлжлэл бөгөөд төсвийг анх батлахдаа макро эдийн засгийн болон түүхий эдийн үнийн таамаглалыг хэт өөдрөгөөр төсөөлсний үр дагавар гэж дүгнэсэн.

Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт орлогыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулж байгаа нь бодит нөхцөл байдлыг тодорхой хэмжээнд залруулж буй эерэг алхам боловч орлогын бууралттай харьцуулахад нийт зарлага, цэвэр зээлийн бууралт хангалтгүй байгааг онцолсон. Орлого буурсан нөхцөлд зарлагыг ижил хэмжээгээр танах зарчмыг баримтлаагүй нь төсвийн алдагдал, өрийн дарамтыг цаашид нэмэгдүүлэх эрсдэл үүсгэж байна.

Төсвийн зарлагын бүтцийн тухайд ДНБ-д урсгал зардлын эзлэх хувь өндөр хэвээр байгаа бөгөөд хөгжиж буй орнуудын дундаж түвшнээс мэдэгдэхүйц давж байгааг анхаарах шаардлагатай гэж үзэв. Төрийн албан хаагчдын тоог бууруулах, зарим үйл ажиллагааг хэмнэх арга хэмжээ тусгасан нь зөв чиглэл боловч эдийн засаг дахь төрийн оролцоог нийтэд нь авч үзвэл өндөр түвшинд хадгалагдсаар байна гэж дүгнэсэн. Түүнчлэн гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийг тооцох аргачлал бодит зах зээлийн нөхцөлөөс зөрүүтэй хэвээр байгаа нь төсвийн орлогыг бодитоос өндрөөр төлөвлөх шалтгаан болж байгаа тул цаашид түүхий эдийн үнийн таамаглалыг олон улсын зах зээлийн бодит мэдээлэлд илүү нийцүүлэн боловсруулах, төсөөллийн нарийвчлалыг сайжруулах шаардлагатайг онцолсон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй түвшинд байгааг харгалзан зарим шинэ төсөл, арга хэмжээг хойшлуулах, ач холбогдлын эрэмбэ тогтоох, төсөвт өртгийн тооцоог дахин хянах нь зүйтэй. Төсвийн хөрөнгө оруулалтыг бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулахгүйгээр олон төсөлд тараан байршуулж байгаа нь хөрөнгийн үр ашгийг бууруулж байна гэж Зөвлөл үзсэн болно.

Нэгтгэн дүгнэвэл, 2025 оны төсвийн тодотголын хүрээнд орлогын бодит нөхцөл байдлыг хүлээн зөвшөөрч тодорхой залруулга хийсэн боловч төсвийн тэлэлтийг хангалттай

хэмжээнд хязгаарлаж чадаагүй, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, мөчлөг сөрсөн бодлогын зарчимтай бүрэн нийцээгүй хэвээр байна. Иймд цаашид төсвийн төлөвлөлтийг сайжруулан тодотголоор бус, урьдчилсан тооцоололд суурилсан бодлогоор шийдвэрлэх, төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлогын цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай юм.

3.8.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах асуудлаарх байр суурь

ТТБЗ нь 2025 онд төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчны талаар байр сууриа илэрхийлж ажилласан. Энэ хүрээнд 2025 оны төсвийн тодотголыг хэлэлцэн батлахтай холбоотойгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулж буй асуудалд Зөвлөлөөс онцгойлон анхаарч, төсвийн бодлогын тогтвортой байдал, сахилга бат, хяналтын тогтолцоонд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг тодорхойлон Зөвлөлийн саналыг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-д хүргүүлсэн.

Тодруулбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр оруулсан өөрчлөлт болон 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн хуулийн төсөл нь Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсаны дараа, мөн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд төсвийн төсөл, төсвийн тодотголыг өргөн мэдүүлэх хугацааны хязгаарлалтыг сулруулах нөхцөлийг бүрдүүлж байгааг Зөвлөлөөс онцолсон. Түүнчлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага буурах тохиолдолд хуульд заасан хязгаарлалтыг баримтлахгүй байх боломжийг бүрдүүлэх зохицуулалт нь төсвийн бодлогын тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлийг нэмэгдүүлнэ гэж үзсэн.

Зөвлөлийн зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5-д заасан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглох” зохицуулалт нь төсвийн бодлогын тогтвортой байдлыг хадгалах, төсвийн орлогын төлөвлөлтийг бодитой хийх, орлогод нийцсэн зарлага төлөвлөх, төсвийн сахилга батыг сайжруулахад онцгой ач холбогдолтой заалт болохыг тодорхойлон тэмдэглэсэн. Гэвч уг заалтыг сулруулах өөрчлөлт орсноор төсвийн орлого тодорхой хэмжээгээр буурах үед Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг дахин өөрчилж, төсвийг тодотгох боломж нэмэгдэхээр байгааг анхааруулсан.

2026 оны төсвийг төлөвлөх, өргөн мэдүүлэх, батлах үйл явцад тодорхой хүндрэл үүсэж байгаа хэдий ч цаашид төсвийн эрх зүйн орчныг дордуулсан, төсвийн сахилга бат, хяналтыг сулруулсан шинжтэй нэмэлт, өөрчлөлтийг давтан хийхгүй байх нь зүйтэй гэж үзсэн. Түүнчлэн 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан “төсвийн орлого, зарлага буурах” гэсэн ерөнхий нөхцөлийг илүү тодорхой болгож, уг зохицуулалтыг нэг удаагийн шинжтэй буюу тодорхой хугацааны хязгаарлалттайгаар найруулах шаардлагатай гэсэн санал, зөвлөмжийг гаргасан. Дээрх байр суурь нь төсвийн бодлогын эрх зүйн орчны тогтвортой байдлыг хамгаалах, төсвийн сахилга бат, хяналтын тогтолцоог сулруулах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улмаар төсвийн тогтвортой байдлыг хангах зорилготой юм.

3.9.Төсвийн төслийг боловсруулах явц дахь 2026 оны төсвийн хязгаар ба олон нийтийн оролцооны талаар өгсөн дүгнэлт

ТТБЗ зөвлөл нь Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулах явцад төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн саналууд Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаарт нийцэж буй эсэх, мөн төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан эсэхэд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр УИХ, Сангийн яаманд хүргүүлсэн. Шинжилгээгээр төсвийн ерөнхийлөн захирагчдын дийлэнх нь Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаарыг баримтлаагүй, урсгал болон хөрөнгийн зардлын саналаа хязгаараас давуулан ирүүлсэн нь төсвийн сахилга бат, хууль тогтоомжийн хэрэгжилт сул байгааг харуулав. Зарим төсвийн ерөнхийлөн захирагчдын хувьд нийт зарлага, ялангуяа хөрөнгийн зардлын санал төсвийн хязгаараас хэд дахин давсан нь төсвийн төлөвлөлт бодлогын түвшинд бус, байгууллагын дотоод хэрэгцээнд тулгуурлан хийгдэж байгааг илтгэж байна.

Төсвийн тухай хуульд зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь жилийн төсвийн хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр үндэслэл, тайлбарын хамт ирүүлэх ёстой боловч бодит байдалд энэхүү зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байна. Энэ нь төсвийн боловсруулалтын шатанд хяналт, хариуцлагын тогтолцоо сул хэвээр байгааг харуулж буй тул цаашид төсвийн хязгаарыг чанд мөрдүүлэх шаардлагатай.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулах явцад Засгийн газраас олон нийтийн хэлэлцүүлгийг салбар бүрээр зохион байгуулж, танхимын болон цахим хэлбэрийг хослуулан өргөн хүрээг хамруулсан нь өмнөх жилүүдтэй харьцуулахад тодорхой ахиц гарсан гэж үзэв. Иргэд, олон нийтийн оролцоо тооны хувьд өргөн байсан бөгөөд олон нийтийн санал асуулгаар төсвийн бодлогын тэргүүлэх чиглэлийн талаар бодит мэдээлэл цуглуулсан нь эерэг үр дүн болсон. Гэсэн ч олон нийтийн хэлэлцүүлгийн чанарын хувьд анхаарах асуудал цөөнгүй байна. Хэлэлцүүлэгт оролцогчдыг хангалттай мэдээллээр хангаагүй, төсвийн төслийг боловсруулахад ашигласан тоон мэдээлэл, судалгаа, аргачлал олон нийтэд нээлттэй бус, танилцуулгын хугацаа хязгаарлагдмал байсан нь иргэд бодитой, судалгаанд суурилсан санал өгөх боломжийг хязгаарласан. Мөн олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналуудын маш бага хувь нь төсвийн төсөлд тусгагдсан нь хэлэлцүүлгийн үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байгаа юм.

Төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт шинээр хэрэгжиж эхэлж байгаа тул бодлогын түвшинд энэхүү оролцоог жинхэнэ утгаар нь хангах, хэлэлцүүлгийг зөвхөн хэлбэр төдий бус бодит шийдвэрт нөлөөлөх механизм болгох шаардлагатай гэж Зөвлөл дүгнэсэн. Үүний тулд төсвийн төслийн ил тод байдлыг хангах, төсвийн хязгаар, хөрөнгө оруулалтын саналын үнэлгээ, эрэмбэлэх үйл явцыг нийтэд нээлттэй болгох, үр дүнд чиглэсэн төсөвлөлтийн тогтолцоог бодитой хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Ерөнхийд нь дүгнэхэд, 2026 оны төсвийн төслийг боловсруулах явцад олон нийтийн оролцооны цар хүрээ нэмэгдсэн нь эерэг хандлага боловч төсвийн хязгаарыг мөрдөх байдал хангалтгүй, сахилга бат сул, төсвийн төлөвлөлт бодлогын баримт бичгүүдтэй бүрэн уялдаагүй, олон нийтийн оролцооны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага хэвээр байгааг онцолсон болно.

3.10.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлт

ТТБЗ нь Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн нөхцөл байдал, дунд хугацааны төсвийн бодлогын зорилттой уялдуулан шинжилж, дүгнэлт гарган 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-д хүргүүлсэн. Шинжилгээгээр дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого нь эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай багасгах, төсвийн тогтвортой байдлыг сэргээх зорилт дэвшүүлсэн нь бодлогын хувьд зөв чиглэл гэж үнэлэв. Сүүлийн жилүүдэд ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх хувь огцом нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх эерэг нөлөө сулрах, хувийн хэвшлийн орон зай хумигдах эрсдэл бий болсон нөхцөлд энэхүү өөрчлөлтийг хийх нь шаардлагатай алхам гэж үзсэн.

Эдийн засгийн таамаглалын хувьд өмнөх төсөөллүүдтэй харьцуулахад илүү болгоомжтой, бодит нөхцөл байдалд ойртсон хандлага ажиглагдаж байгаа нь дунд хугацааны төсвийн бодлогын суурийг илүү бодитой болгох боломжийг бүрдүүлж байна. Ялангуяа ойрын хугацааны эдийн засгийн өсөлтийн таамаглалыг бууруулж, дунд хугацаанд тогтвортой өсөлтийг хадгалах чиглэл баримталсан нь эерэг өөрчлөлт гэж дүгнэв. Гэхдээ төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь дунд хугацаанд буурах төлөвтэй байгаа боловч эдийн засгийн өсөлтийг хамгийн их дэмжих оновчтой түвшинд хараахан хүрэхгүй хэвээр байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн төсвийн зарлагын бүтэц, ялангуяа нийгмийн халамж, урсгал зардлын өндөр өсөлт нь цаашид төсвийн тусгай шаардлагуудыг хангахад хүндрэл үүсгэх эрсдэлтэй байгааг Зөвлөл онцолсон. Үүний зэрэгцээ эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлага хэвээр байна. Өмнөх жилүүдэд эдийн засаг тэлж, төсвийн орлого нэмэгдсэн үед хуримтлал үүсгэх боломжийг бүрэн ашиглаагүй нь өнөөгийн төсвийн дарамтыг бий болгосон тул цаашид эдийн засгийн тэлэлт, агшилтын аль ч үед мөчлөг сөрсөн бодлогыг жигд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэв.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд оруулж буй өөрчлөлтүүд нь бодлогын баримт бичгийн тогтвортой байдал, залгамж чанарыг сулруулж байгаа учир цаашид Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийг дагаж өөрчилдөг бус, төсвийг чиглүүлэгч бодлогын баримт бичиг байх зарчмыг тууштай мөрдөх шаардлагатай гэж үзсэн.

Нэгтгэн дүгнэхэд, 2026–2028 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд оруулсан өөрчлөлт нь төсвийн тэлэлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх чиглэлд тодорхой ахиц гаргасан боловч төсвийн зарлагын бүтэц, орлогын төлөвлөлтийн бодитой байдал, мөчлөг сөрсөн бодлогын тууштай хэрэгжилтийг хангах чиглэлээр цаашид онцгой анхаарах шаардлага тулгарсан хэвээр байна.

3.11.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлт

Тус зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн нөхцөл байдал, дунд хугацааны төсвийн бодлогын зорилттой уялдуулан шинжилж, дүгнэлт гарган, 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-д хүргүүлсэн. Шинжилгээгээр 2026 оны төсвийн

бодлогын чиглэл нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийн орон зайг нэмэгдүүлэхэд чиглэсэн нь бодлогын хувьд зөв хандлага гэж үзэв. Өмнөх жилүүдэд эдийн засгийн таатай мөчлөгийг даган төсвийн зарлага огцом тэлж ирсэн нөхцөлд энэхүү чиглэл нь төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг сэргээхэд чухал ач холбогдолтой юм.

Төсвийн бодлогын тогтвортой байдлын хувьд эдийн засгийн хүндрэлтэй үед төсвийг хумих, харин эдийн засаг тэлэх үед зарлагыг нэмэгдүүлэх хандлага давтагдаж ирснийг цаашид таслан зогсоож, мөчлөг сөрсөн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатайг Зөвлөл онцолсон. Төсвийн бодлого нь нэг удаагийн нөхцөл байдлаас хамаарах бус, дунд болон урт хугацаанд тогтвортой, залгамж чанартай хэрэгжих ёстой гэж үзэв.

Хөгжлийн бодлого болон төсвийн төлөвлөлтийн уялдааг хангасан эсэхийн тухайд 2026 оны төсвийн төсөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй ерөнхийдөө уялдаж байгаа боловч Монгол Улсыг хөгжүүлэх 2026–2030 оны таван жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байхад 2026 оны төсвийг Засгийн газар боловсруулан өргөн барьж, УИХ-аар хэлэлцэж буй нь бодлогын дараалал алдагдах эрсдэл үүсгэж байгааг анхааруулсан. Энэ нь хөгжлийн бодлого, төсөв, санхүүгийн уялдааг сулруулах сөрөг нөлөөтэй гэж дүгнэсэн.

Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд төсвийн болон мөнгөний бодлогын уялдааг сайжруулах шаардлага тулгарсан хэвээр байна. Инфляц зорилтот түвшнээс өндөр, төлбөрийн тэнцэл алдагдалтай, гадаад зах зээл дэх түүхий эдийн үнэ буурах хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд төсвийн бодлого нь мөнгөний бодлоготой зөрчилдөх бус, харин харилцан дэмжих байдлаар хэрэгжих нь чухал гэж үзсэн.

Төсвөөр дамжуулан эдийн засгийн хөгжлийг дэмжих боломж хумигдаж байгааг Зөвлөл онцолсон. Урсгал зардлын өсөлт нь нэрлэсэн ДНБ-ий өсөлтөөс давсан хэвээр үргэлжилбэл ойрын жилүүдэд төсвийн орлого урсгал зардлаа л даах түвшинд хүрч, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогыг дэмжих санхүүгийн орон зай багасах эрсдэлтэй байна. Иймд урсгал зардлыг нэмэгдүүлж буй хууль, эрх зүйн зохицуулалтыг эргэн харах шаардлагатай гэж дүгнэв. Үүнээс гадна төсөв, санхүүгийн эрх зүйн орчны тогтвортой байдалд анхаарах шаардлагатайг тэмдэглэсэн. Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулж ирсэн нь төсвийн бодлогын дархлааг сулруулж, дунд хугацааны төлөвлөлтийн ач холбогдлыг алдагдуулж байгааг Зөвлөл анхааруулсан.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь өмнөх жилүүдтэй харьцуулахад бодлогын хувьд тодорхой хэмжээгээр сайжирч, төсвийн тэлэлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах чиглэлд ахиц гаргасан боловч төсвийн бодлогын тогтвортой байдал, хөгжлийн бодлого, төсвийн уялдааг хангах, урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, макро эдийн засгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр цаашид онцгой анхаарах шаардлагатай хэвээр байна гэж дүгнэв.

3.12. Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас 2026–2028 оны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах талаар гаргасан саналд өгсөн дүгнэлт

ТТБЗ нь УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн хороодын хамтарсан хуралдаанаас гарсан саналд үндэслэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн

төслийн талаар дүгнэлт гаргаж, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Зөвлөлөөс нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан төсвийн тусгай шаардлагад нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр нэмэгдэл орлогын эх үүсвэр тодорхойгүй, орлогын тооцооны аргачлалд бодит өөрчлөлт ороогүй нөхцөлд орлогын дүнг нэмэгдүүлэх нь төсвийн төлөвлөлтийн бодитой байдалд эрсдэл үүсгэж болзошгүй гэж үзэв.

Нэгдсэн төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэх өөрчлөлт нь нэрлэсэн ДНБ-д тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлэх боловч уг өсөлт нь эрэлтээс үүдэлтэй үнийн өсөлтөөр дамжин бий болох шинжтэй тул бодит эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үр нөлөө хязгаарлагдмал. Үүний зэрэгцээ татварын дараах орлого буурах, хувийн хэвшлийн хөдөлмөр эрхлэлт, үйлдвэрлэлийн шийдвэрт сөрөг орлуулалтын нөлөө үүсэх магадлалтай гэж дүгнэв.

Макро түвшинд авч үзвэл, санал болгосон өөрчлөлтийн нөлөөгөөр эдийн засгийн нийт эрэлт өсөх боловч нийт нийлүүлэлт буурах буюу өөрчлөгдөхгүй байж болзошгүй бөгөөд энэ нь инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Үүний улмаас нэрлэсэн ДНБ өсөх хэдий ч суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь буурч, дунд хугацаанд суурь тэнцэл ДНБ-ий 2 хувь буюу түүнээс дээш ашигтай байх төсвийн тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэхээр байгааг Зөвлөл онцолсон. Мөн Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнд уг өөрчлөлт шууд нөлөөлөхгүй боловч ДНБ-д эзлэх харьцаанд өөрчлөлт орох нь суурь тэнцлийн шалгуурт нөлөөлөх замаар төсвийн тогтвортой байдлын үндсэн үзүүлэлтүүдийг алдагдуулах эрсдэл дагуулж байна. Түүнчлэн Төсвийн хүрээний мэдэгдлийг дагуулан төсвийн зарлагыг өөрчлөх боломж үүсэх нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төсвийн эрх зүйн зарчимтай зөрчилдөх нөхцөл бүрдүүлж болзошгүй гэж дүгнэв.

Иймд ТТБЗ-өөс дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал нь Төсвийн хүрээний мэдэгдэл болон Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн төсөлд тус тус төсвийн суурь тэнцлийн тусгай шаардлагыг зөрчих, мөн төсвийн эрх зүйн тогтвортой байдалд эрсдэл үүсгэх тул холбогдох хуулийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дахин явуулах нь зүйтэй гэж дүгнэсэн болно.

3.13. Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад гаргасан саналуудын талаарх дүгнэлт

ТТБЗ нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналуудтай холбогдуулан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дүгнэлт гарган 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр УИХ-д хүргүүлсэн.

Энэ хүрээнд төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн үе шатанд УИХ-ын гишүүд, Байнгын болон дэд хороо, ажлын хэсгээс төсвийн орлого, зарлагад өөрчлөлт оруулахтай холбоотой нийт 112 зарчмын зөрүүтэй санал гаргаснаас 61 санал холбогдох Байнгын болон дэд хороо, ажлын хэсгээр дэмжигдэж, эдгээрээс 31 санал Төсвийн байнгын хорооны хуралдаанаар эцэслэн дэмжигдсэн байна. Дэмжигдсэн саналуудын нийт өртөг нь 2026 оны төсвийн төслийн нийт зарлагын 4.38 хувьтай тэнцэж байв. Дэмжигдсэн саналуудын хүрээнд

урсгал зардлыг 988.6 тэрбум төгрөгөөр бууруулж, 953.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх, хөрөнгийн зардлыг 457.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 490.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх өөрчлөлт хийгдсэн бөгөөд үүний үр дүнд нийт зарлагын цэвэр өөрчлөлт 1.4 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь төсвийн нийт зарлагын дүнд тодорхой дарамт үүсгэх хэмжээнд байгааг Зөвлөл анхааруулсан. Төсвийн төсөлд оруулсан эдгээр өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн орлого, зарлагын дээд хэмжээг нэмэгдүүлэхгүй байх зарчимтай нийцэж байгаа боловч төсвийн бодлогын чанар, уялдаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл дагуулж байгааг онцлов. Мөн дэмжигдсэн саналууд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг хангаж байгаа боловч дунд хугацаанд төсвийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан авч үзэх шаардлагатай гэж дүгнэв.

Хөрөнгийн зардлын хувьд давхардсан болон хэрэгжилтийн бэлтгэл хангагдаагүй 230 төсөл, арга хэмжээг хасах, төсөвт өртөг болон 2026 онд санхүүжих дүнг бууруулах замаар зохицуулалт хийсэн хэдий ч үүний зэрэгцээ 138 шинэ төсөл, арга хэмжээг нэмж, 6 төсөл, арга хэмжээний зардлыг нэмэгдүүлсэн нь хасагдсан төслүүдийн санхүүжилтээс илүү хэмжээний зардлын дарамт үүсгэж байна. Ингэснээр хөрөнгийн зардлын бүтэц дунд хугацаанд тэлэх хандлага хэвээр байгааг Зөвлөл тэмдэглэсэн.

Шинээр нэмэгдсэн зарим төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуульд заасан шалгуурыг бүрэн хангаагүй, тухайлбал, хэрэгжүүлэх хугацаанд жигд санхүүжилттэй байх, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлал бүрэн хийгдсэн байх шаардлагыг хангаагүй тохиолдол цөөнгүй байгааг дурдсан. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эрэмбэ дараалал алдагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн шинээр төсөл нэмэх зорилгоор өмнө нь төсөвт тусгагдсан зарим төслийн санхүүжилтийг бууруулж байгаа нь тухайн төслүүдийг хуульд заасан шаардлагыг хангахгүй байдалд хүргэж, төсвийн төслийн чанарт сөргөөр нөлөөлж байгааг Зөвлөл анхааруулсан. Зарим саналын хувьд ямар бодлого, шалгуур баримталж сонгосон нь тодорхойгүй, үр дүнгийн үзүүлэлт дутуу байгаа нь төсвийн бодлогын тууштай байдлыг сулруулж байна гэж үзсэн.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад гарсан саналууд нь хууль зүйн хувьд тодорхой шаардлагыг хангаж байгаа боловч зарлагын бүтэц, хөрөнгө оруулалтын бодлогын уялдаа, төсвийн төлөвлөлтийн чанар, дунд хугацааны тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөр хэвээр байна гэж дүгнэсэн. Цаашид төсвийн төсөлд өөрчлөлт оруулахдаа бодлогын уялдааг хангаж, тооцоо судалгаанд суурилсан шийдвэр гаргахыг чухалчлах шаардлагатай.

3.14. Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийн талаарх санал

ТТБЗ нь Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төслийг холбогдох хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төсөв, санхүүгийн нөөцийн уялдаа, хэрэгжилтийн бодит боломжийн хүрээнд судалж, дараах саналуудыг 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д хүргүүлсэн. Хөгжлийн бодлогын үндсэн чиглэл, ач холбогдол, эрэмбэ дарааллыг илүү тодорхой, бодлогын суурьтайгаар тодорхойлох шаардлагатай гэж дүгнэсэн. Төсөлд бодлогын 8 үндсэн чиглэл, үндэсний хэмжээний 10 томоохон үр дүнг тусгасан боловч эдгээрийн хоорондын логик уялдаа, аль чиглэл нь хөгжлийн суурь, аль нь үр дүн болох нь тодорхой бус байна. Хүний хөгжлийг нэн тэргүүний зорилт болгон тодорхойлсон нь ач холбогдолтой боловч эдийн засгийн өсөлт, өмчийн болон эдийн засгийн

эрх чөлөөг хангах бодлогын суурь тодорхойгүй нөхцөлд хүний хөгжлийг тогтвортой хангах боломж хязгаарлагдмал байгааг анхаарах шаардлагатай гэж үзэв.

Бодлогын зорилтуудын хэрэгжилтийн хувьд арга хэмжээний цар хүрээ хэт өргөн байгаа нь үндсэн зорилтуудын хэрэгжилтийг сарниулах эрсдэлтэй. Ядуурал, ажилгүйдэл, өрхийн бодит орлого, дундаж давхарга, боловсрол, эрүүл мэнд зэрэг тулгамдсан асуудлуудад төвлөрч, хэрэгжилт, үнэлгээ, хариуцлагын механизмыг тодорхой болгох шаардлагатайг онцолсон. Хүн амын тодорхой хэсэг ядуурлын түвшинд буюу түүнтэй ойролцоо амьдарч буй өнөөгийн нөхцөлд хөгжлийн бодлогын зорилтууд бодитой хэрэгжихэд хүндрэлтэй байгааг тэмдэглэв. Төслийн хоёрдугаар хавсралтад тусгагдсан төсөл, арга хэмжээний тоо, агуулга нь хөгжлийн бодлогын үндсэн чиглэл гэхээс илүүтэй төрийн байгууллагуудын хийх ажлын жагсаалт хэлбэртэй болж, бодлогын баримт бичгийн агуулгыг бүрхэг болгож байгааг анхаарах хэрэгтэй гэж үзсэн. Зарим арга хэмжээ нь хөгжлийн бодлогын түвшинд хамаарах эсэх нь тодорхойгүй, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны чанартай асуудлуудыг хамарсан шинжтэй байгааг дүгнэсэн.

Хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт, үр дүнг хэмжих тогтолцоо сул байгааг онцолж, бодлогын 8 чиглэлд үндэсний, салбарын, төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшний хэт олон зорилт, үзүүлэлт дэвшүүлсэн нь хэрэгжилтийг бодитоор үнэлэх боломжийг алдагдуулах эрсдэлтэй гэж үзэв. Иймд үр дүнг хэмжих үзүүлэлтүүдийг цөөн, тодорхой, хэмжигдэхүйц, бодлогын зорилттой шууд уялдсан байдлаар тодорхойлох шаардлагатай юм. Агаар, орчны бохирдлын асуудлыг тусгайлан, бие даасан бодлогын түвшинд авч үзэх шаардлагатайг санал болгосон. Өнгөрсөн хугацаанд ихээхэн хөрөнгө, нөөц зарцуулсан хэдий ч агаар, хөрс, усны бохирдол, ялангуяа нийслэл хотын нөхцөл байдал эрүүл мэндэд эрсдэлтэй түвшинд хэвээр байгааг харгалзан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр-2”-ыг шинээр боловсруулж, 5 жилийн үндсэн чиглэлийн салшгүй хэсэг болгон батлах нь зүйтэй талаар санал гаргасан.

Мөн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг төсвийн багцтай уялдуулах, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бодлогын зорилттой логик уялдаатай болгох шаардлагатайг онцолсон. Үр дүнгийн үзүүлэлтүүдийг “гарц”-д бус “үр нөлөө”-д чиглэсэн байдлаар шинэчлэх, дижитал хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем нэвтрүүлэх нь бодлогын хэрэгжилтийг сайжруулах ач холбогдолтой гэж үзсэн.

Хөгжлийн бодлогын хүрээнд хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг макро эдийн засгийн нөхцөл, санхүүжилтийн бодит боломжтой нийцүүлэх шаардлагатай. Үүнээс гадна техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төслүүд нь төсөвт гэнэтийн дарамт үүсгэх, хэрэгжилт удаашрах, үр ашиггүй зардал бий болгох эрсдэлтэйг анхааруулсан. Түүнчлэн зарим томоохон мега төслүүдийн хэрэгжилтийн бодит боломж, эдийн засаг, нийгмийн үр ашгийг дахин нягтлах, ач холбогдлын эрэмбэ тогтоож, зарим төслийг хасах, хойшлуулах замаар төлөвлөлтийн чанарыг сайжруулах боломжтой.

Түүнчлэн хөгжлийн бодлогын хүрээнд шинээр нийслэлд нийгмийн хариуцлагын онооны систем нэвтрүүлэх, тэтгэврийн хувийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх зэрэг зорилтыг тусгах санал гаргасан нь хүний хөгжил, нийгмийн хариуцлага, урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг дэмжих ач холбогдолтой гэж дүгнэсэн.

Эндээс нэгтгэн, Монгол Улсыг 2026–2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн төсөл нь бодлогын хувьд өргөн хүрээг хамарсан боловч бодлогын суурь, эрэмбэ дараалал,

хэрэгжилтийн механизм, санхүүжилтийн бодит боломж, үр дүнг хэмжих тогтолцоог илүү тодорхой, цогц байдлаар сайжруулахыг санал болгов.

3.15. “Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд өгсөн санал

ТТБЗ нь УИХ-ын “Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай” тогтоолын төслийг холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, төсөв болон мөнгөний бодлогын уялдааны хүрээнд судалж, санал гарган 2025 оны 12 дугаар сарын 29-ний өдөр УИХ-д хүргүүлсэн.

Зөвлөлөөс уг тогтоолын төслийн зорилго, агуулга нь үнийн өсөлтийн үр дагаварт төвлөрсөн байгааг анхаарч, үнийн өсөлтийн суурь шалтгааныг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын хандлагыг илүү тодорхой тусгах шаардлагатай гэж үзсэн. Учир нь инфляц нь эдийн засгийн бүтцийн сул тал, ажлын байр, орлогын тогтвортой өсөлт хангалтгүй байдал, эдийн засгийн эрх чөлөөний хязгаарлалттай шууд уялдаатай тул эдгээр суурь асуудлыг шийдэхгүйгээр үнийн өсөлтөөс иргэдийг хамгаалах бодит үр дүн гарах боломж хязгаарлагдмал гэж үзсэн.

Макро эдийн засгийн бодлогын хувьд тогтоолын төсөлд инфляц, хүү, валютын нөөц, төсвийн тэлэлт зэрэг асуудлыг голчлон Монголбанк, Засгийн газар, Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэх арга хэмжээгээр тодорхойлсон боловч эдгээр бодлогын үр дүн нь зөвхөн нэг байгууллагын шийдвэрээс бус, улс төр, эдийн засаг, нийгмийн нийт нөхцөл байдлаас ихээхэн хамааралтайг харгалзан үзэх шаардлагатайг онцлов.

Уг тогтоолын төсөлд тусгагдсан зарим арга хэмжээ нь эдийн засгийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлөх, иргэдийн өмч, бизнес эрхлэх эрхийг хязгаарлах эрсдэлтэй байж болзошгүйг анхааруулсан. Тухайлбал, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын харилцан хамаарал бүхий этгээдтэй холбоотой зохицуулалтыг хэт өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь бодит үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай гэж үзсэн.

Төсвийн бодлогын хүрээнд тогтоолын төсөлд тусгагдсан төсвийн тэлэлтийг хязгаарлах, үр ашиггүй зардлыг бууруулах, уул уурхайн салбараас төсвийн хамаарлыг багасгах чиглэл нь Зөвлөлийн баримталж буй бодлоготой нийцэж байгааг дүгнэсэн. Гэсэн хэдий ч төсөв, мөнгөний бодлогын уялдааг илүү тодорхой болгож, бодит механизмаар тусгах шаардлагатай төдийгүй ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувийг зохистой түвшинд барих, урсгал зардлыг бодлогын түвшинд бууруулах зорилтыг илүү тодорхой болгох нь зүйтэй гэсэн санал гаргасан.

Цалин хөлс, урсгал зардал, төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэгтэй холбоотой заалтуудын хувьд инфляцтай автоматаар уялдуулах бус, төрийн албаны бүтцийн оновчлол, үр ашиг, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын тогтолцоотой уялдуулан авч үзэх шаардлагатай гэж дүгнэсэн. Түүнчлэн Засгийн газрын тусгай сангуудыг цөөлөх, татан буулгахтай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ тухайн сангуудын зайлшгүй хэрэгцээтэй чиг үүрэг, урт хугацаанд үзүүлэх нөлөөллийг нарийвчлан үнэлэх шаардлагатайг онцолсон.

ТТБЗ-өөс “Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай” УИХ-ын тогтоолын төсөл нь өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд ач холбогдолтой боловч үнийн өсөлтийн суурь шалтгаанд чиглэсэн бодлогын арга хэмжээг илүү тодорхой болгож, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хувийн хэвшлийн хөгжих орон зайг тэлэх, иргэдийн бодит

орлогыг нэмэгдүүлэх чиглэлд бодлогын уялдаа, хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж саналаа хүргүүлсэн.

3.16.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн орчны талаарх санал

ТТБЗ нь 2025 онд хуульд заасан чиг үүргийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын тогтолцоог сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашиг, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн шинэчлэлийн асуудалд идэвхтэй оролцож, холбогдох байр сууриа илэрхийлж, санал боловсруулан хүргүүлсэн болно.

Энэ хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Засгийн газраас боловсруулсан “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай” хуулийн төслийг судалж, Зөвлөлөөс төсвийн хөрөнгө оруулалтын талаар баримталж ирсэн бодлого, өмнө нь өгч байсан дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд саналаа нэгтгэн хүргүүлсэн. Тус хуулийн төслийг санаачлан боловсруулж буй нь төсвийн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах зорилготой, бодлогын хувьд ач холбогдолтой алхам болохыг Зөвлөлөөс онцлохын зэрэгцээ хуулийн төслийн зохицуулалт нь хөрөнгө оруулалтыг төлөвлөх, эрэмбэлэх, төсөвт тусгах, хэрэгжүүлэх үе шатанд тулгамдаж буй алдаа дутагдлыг бодитоор засах боломжийг бүрдүүлж чадах эсэхийг нухацтай авч үзэх шаардлагатай гэж үзсэн.

Түүнчлэн хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын зарчмуудыг тусгасан нь сайшаалтай боловч улсын болон төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөлт, удирдлагын тогтолцоо бүрдээгүй нөхцөлд төсвийн ерөнхийлөн захирагчдын зүгээс ач холбогдол, үр ашиг багатай олон тооны хөрөнгө оруулалтын санал ирүүлэх эрсдэл хэвээр үлдэхийг анхааруулж, уг тогтолцоог илүү тодорхой, хэрэгжихүйц байдлаар тусгах шаардлагатай гэсэн санал өгсөн.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн үе шат, цаглаврын зохицуулалт нь зөвхөн төлөвлөлтийн хэсэгт төвлөрч, хэрэгжилт, хяналтын үе шатны нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаагаас хуулийн хэрэгжилт сулрах, хяналт алдагдах эрсдэл үүсэж болзошгүйг тодорхойлон, төслийн бүх үе шатанд тавих хяналтыг бодитой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзсэн. Төслийн сонголтод ашиглах “эдийн засгийн үр ашиг”, “нийгмийн ач холбогдол” зэрэг шалгуур, нэр томъёоны тодорхойлолт нь бодит хэрэглээнд тодорхой бус, хоёрдмол ойлгогдох эрсдэлтэй байгааг онцолж, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуультай уялдуулах, нэр томъёог нэг мөр, зөрчилгүй, шинжлэх ухааны үндэслэлтэй байдлаар тодорхойлох шаардлагатай гэсэн байр суурийг Зөвлөлөөс илэрхийлсэн.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын төслийн эдийн засаг, нийгмийн үр ашгийг үнэн зөв тооцоолох, урьдчилсан үнэлгээ хийх хүний нөөц, ялангуяа барилгын зураг төсөл, төсөв тооцоолол боловсруулах мэргэжилтний хүрэлцээ хангалтгүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлж буй тул хуулийн төслийг хэлэлцэх явцад энэ асуудлыг тусгайлан анхаарч, бодлогын шийдвэр гарган хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Дээрх саналууд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн чанарыг сайжруулах, төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, улмаар төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлд бодитой үр нөлөө үзүүлэх зорилготой юм.

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг

2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт ТТБЗ-өөс Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулах явц, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төсвийн орлогын болон зарлагын төлөвлөлтийн суурь таамаглал, инфляц, Засгийн газрын өрийн өнөөгийн байдал зэрэг бүхий л гол асуудлыг хамруулан танилцуулсан.

Хэлэлцүүлэгт мөн Үндэсний аудитын газар, Сангийн яам, Монголбанк, олон улсын байгууллагуудын төлөөлөл, салбарын мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл идэвхтэй оролцож, төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг олон нийтээр хэлэлцэн санал солилцож, уг төслийг боловсруулахдаа анхаарах асуудлууд, цаашид баримтлах бодлогын чиглэлүүдийн талаар харилцан ярилцлаа.

Уулзалтад оролцогчдын зүгээс дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлахдаа макро эдийн засгийн бодит нөхцөл байдалд нийцсэн таамаглал, төсвийн зарлагын бүтэц, хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл, мөн төсвийн орлогын эх үүсвэр, татварын бодлогын уялдаа зэрэгт илүү их анхаарах шаардлагатай гэсэн санал гаргаж, харилцан саналаа солилцсон. Түүнчлэн оролцогчид олон нийтийн хэлэлцүүлэг нь төсвийн бодлогын үнэлгээ, ил тод байдал, олон нийттэй харилцах холбоог сайжруулах чухал механизм болохыг онцлон тэмдэглэж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулах явцад олон талын оролцоо, санал хуваалцах боломжийг бүрдүүлсэн нь иргэний нийгэм, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чухал алхам болсон гэж дүгнэсэн юм.

4.2. Төсвийн төслийн боловсруулалтын шатны хэлэлцүүлэг

Төсвийн тухай хуульд заасан Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулах явцад салбар бүрээр зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлгүүдэд Зөвлөлийн гишүүдийн оролцсон. 2025 оны 08 дугаар сарын 04-14-ний өдрүүдэд зохион байгуулсан салбарын хэлэлцүүлгүүдийн үеэр Зөвлөлийн гишүүд салбарын төсвийн бодлогын чиглэл, төсвийн хязгаарыг мөрдөх байдал, төсвийн сахилга бат, үр ашигтай зарцуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зардлын өсөлтөөс үүсэх төсвийн эрсдэлийн асуудлыг онцлон авч үзэж, хэлэлцүүлэгт оролцогчдын тавьсан асуулт, санал, байр суурийг бодлогын түвшинд нэгтгэн дүгнэсэн.

Зөвлөлийн гишүүдийн оролцоо нь олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр зөвхөн мэдээлэл сонсох түвшинд бус төсвийн төсөл боловсруулах эрх бүхий байгууллагуудын танилцуулсан мэдээллийг төсвийн хууль тогтоомжийн шаардлага, төсвийн тогтвортой байдлын шалгууртай уялдуулан үнэлэх, төсвийн төсөлд тусгагдсан арга хэмжээ, хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийн үр ашиг, бодлогын нийцлийг хэлэлцүүлгийн индэр дээрээс тодруулж асуух, олон нийтийн гаргасан саналыг эрэмбэлэх, нэгтгэх үйл явцын ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн байр суурийг илэрхийлэхэд чиглэсэн. Түүнчлэн хэлэлцүүлгийн үеэр төсвийн хязгаарыг баримтлах, зардлын өсөлтийг хязгаарлах, үр дүнд чиглэсэн төсөвлөлтийг төлөвшүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтын үндэслэл, ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагын талаар Зөвлөлийн зүгээс анхаарал хандуулсан.

Мөн Зөвлөлөөс 2026 оны төсвийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн зохион байгуулалт, оролцооны үр дүнд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн хэлэлцүүлгийн үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай зарим асуудлыг тодорхойлж, тухайлбал мэдээллийн ил тод байдал хангалтгүй, оролцогчдыг танилцуулга, мэдээллээр хангах байдал сул, хэлэлцүүлгийн цаг хугацаа шахуу зэрэг хүндрэлүүд байсныг онцлон тэмдэглэж, цаашид олон нийтийн оролцоог бодлогын түвшинд бодитоор нэмэгдүүлэх, хэлэлцүүлгийн зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр санал боловсруулан ажилласан.

4.3. Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлэг

Нээлттэй нийгэм форум болон ТТБЗ хамтран “Монгол Улсын 2026 оны төсвийн төлөвлөлт” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээ нь ирэх оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөл боловсруулалтын явц, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, бодлогын уялдаа зэрэг гол асуудлуудыг олон талын оролцоотой хэлэлцэх зорилготой байв.

Хэлэлцүүлэгт ТТБЗ-өөс 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027–2028 оны төсвийн төсөөллийн талаарх дүгнэлтээс гадна төсвийн бодлого, зарцуулалтын чиг хандлага, макро эдийн засгийн орчинд анхаарах асуудлуудыг танилцуулсан бөгөөд Сангийн яам 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар илтгэл тавьсан. Мөн судлаач Д.Баярмаа 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн төлөвлөлтөд хийсэн дүн шинжилгээний үр дүнг танилцуулсан. Хэлэлцүүлэгт Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, Үндэсний статистикийн хороо зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн төлөөлөл идэвхтэй оролцож, хэлэлцэж буй асуудлуудаар өргөн хүрээнд санал бодлоо илэрхийлсэн.

ТТБЗ-өөс уг хэлэлцүүлгийн явцад онцлон тэмдэглэсэн гол асуудлууд нь дараах байдалтай байв. Үүнд:

- 2026 оны төсвийн төсөлд урсгал зардлын өсөлт нөлөөллийн тал дээр бодлогын уялдаа хангалтгүй байгааг онцлон дурдсан бөгөөд зарим салбарын зардлын өсөлтийн хяналт сул байгааг илэрхийлсэн;
- хөрөнгө оруулалтын төслүүдийн санал болгосон жагсаалт нь эдийн засгийн бодлогын тэргүүлэх чиглэлтэй бүрэн уялдаагүй, хэрэгжилтийн бэлтгэл, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй төслүүд байгааг тодруулсан;
- төсөл боловсруулах явцад макро эдийн засгийн нөхцөл байдал, түүхий эдийн үнийн савлагаа, төсвийн орлого бүрдүүлэлтийн эрсдэл зэрэг олон хүчин зүйлийг бодитой үнэлээгүй байгаа нь төсөв батлах, хэрэгжүүлэх явцад эрсдэл үүсгэх нөхцөлийг бий болгох магадлал өндөр гэж дүгнэсэн.

Хэлэлцүүлгийн үеэр оролцогчид мөн бодлогын тэргүүлэх чиглэл, хөгжлийн стратегитай төсвийн уялдаа, төсвийн зарцуулалтын ил тод байдал, төсвийн төлөвлөлтийн бүх шатанд



олон нийтийн оролцоо, үнэлгээний тогтолцоог сайжруулах шаардлагатай байгааг онцлон ярилцсан. Үүний зэрэгцээ төсвийн орлого бүрдүүлэлтийн бүтэц, түүний дундах татварын орчны нөлөө, татварын дарамтын асуудал, хувийн хэвшлийн орон зайг нэмэгдүүлэх бодлогын чиглэл, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих механизмыг илүү бодитой тусгах хэрэгтэйг олон талын оролцогчид онцолсон.

Энэхүү хэлэлцүүлэг нь 2026 оны төсвийн төслийг боловсруулж, батлах явцад бодлогын олон талын санал, шүүмжлэлийг нээлттэй хэлэлцэх, Зөвлөлийн дүгнэлт, судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, иргэний нийгэм ба төрийн байгууллагын хамтын оролцоог сайжруулах чухал боломж болсон бөгөөд хэлэлцүүлгийн явцад гарсан санал, дүгнэлт, шүүмжлэлийн үндсэн агуулгыг төсвийн төсөлд тусгах нь бодлогын тууштай байдал, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал үр нөлөөтэй гэж ТТБЗ үзсэн болно.

4.4.БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албатай хамтран ажилласан нь

Зөвлөлийн дарга Н.Энхбаяр, гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар А.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөл 2025 оны 12 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсад албан томилолтоор ажилласан. Энэ хүрээнд БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн алба (National Assembly Budget Office) болон Санхүүгийн мэдээллийн төв (Financial Information Service)-ийн үйл ажиллагаатай тус тус танилцаж, Зөвлөлийн үйл ажиллагаагаа танилцуулан, макро эдийн засгийн төлөвлөлт, төсөөлөл, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар харилцан мэдээлэл солилцож, төсөв, санхүүгийн мэдээллийн удирдлага, дүн шинжилгээ, цахим систем, ил тод байдлын дэвшилтэт туршлагыг судлан Зөвлөлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломж, чиглэлийг тодорхойлох зорилгоор ажилласан.

Санхүүгийн мэдээллийн төвтэй 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдөр албан уулзалт хийж, төрийн санхүүгийн мэдээллийг нэгтгэн удирдах тогтолцоо, төсөв болон нягтлан бодох бүртгэлийн цахим системийн шийдэл, өгөгдөл цуглуулах, баталгаажуулах, түгээх процесс, нээлттэй өгөгдлийн бодлого, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, төрийн татаас олгох төслийн үйл явцыг удирдах механизм, кибер аюулгүй байдлын шийдлүүдийн талаар дэлгэрэнгүй танилцаж санал солилцсон. Уулзалтын хүрээнд төсөв, гүйцэтгэл, өр, баталгаа, орон нутгийн санхүү, төрийн өмчит аж ахуйн нэгжийн мэдээллийг хамарсан нэгдсэн мэдээллийн сангийн бүтэц, стандартчилсан өгөгдөл дамжуулах зохицуулалт, олон нийтэд мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр түгээх аргачлал, мэдээллийн аюулгүй байдлыг олон давхаргат хамгаалалтаар хангах туршлага нь Монгол Улсын нөхцөлд хэрэгжүүлэх боломжтой сайн туршлага болохыг тодорхойлсон.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албатай 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр албан уулзалт хийж, парламентын дэргэдэх хараат бус төсвийн шинжилгээний байгууллагын эрх зүйн зохицуулалт, институтын зохион байгуулалт, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэх, батлах үе шат бүрд хараат бус дүн шинжилгээ хийх арга зүй, дунд болон урт хугацааны төсвийн төлөвлөлтийн аргачлал, макро эдийн засгийн төсөөлөл боловсруулах туршлага, төсвийн гүйцэтгэлийг хянах, үнэлэх систем, урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээний давтамж, мөн төсвийн бодлого болон урт хугацааны хөгжлийн зорилтуудын уялдаа холбооны талаар туршлага судалж санал солилцсон. Түүнчлэн төсөв, санхүүгийн мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах үйл ажиллагааг цахим системд суурилан хэрэгжүүлдэг шийдэл, стандартчилсан

тайланг олон нийтэд тогтмол хүргэх тогтолцоо нь ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг онцлон тэмдэглэв.

Үүний үр дүнд Зөвлөлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх боломжтой сайн туршлагын хүрээнд төсөв, санхүүгийн мэдээллийг бодлогын шийдвэрт ашиглах тогтолцоог сайжруулах, дунд болон урт хугацааны төсвийн эрсдэлийг тооцох загвар, аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх, санхүүгийн мэдээллийн нэгдсэн цахим системийг хөгжүүлэх, өгөгдлийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх хамтарсан сургалт, туршлага солилцох тогтвортой хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлсон.

Мөн БНСУ-ын Үндэсний Ассамблейн Төсвийн албанаас цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2026 оны 04 дүгээр сард дахин уулзалт зохион байгуулах санал дэвшүүлсэн нь олон улсын хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, Зөвлөлийн институтын чадавхыг нэмэгдүүлэхэд бодит боломж бүрдүүлсэн гэж үзэж байна.

4.5.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагаа

ТТБЗ нь 2025 онд төсвийн бодлогын ил тод байдал, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор хэвлэл мэдээлэл, олон нийттэй тогтмол харилцаж ажилласан. Энэ хүрээнд Зөвлөлийн албан ёсны байр суурь, дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд хүргэхдээ хэвлэлийн бага хурал, хэвлэл мэдээллийн байгууллагын ярилцлага, мэдээллийн сайт, телевиз, цахим орчин, нээлттэй хэлэлцүүлгийн арга хэмжээг зэргийг ашиглан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлсэн.

Зөвлөлөөс төсвийн бодлогын гол баримт бичгүүдтэй холбоотой дүгнэлт, зөвлөмжүүдийг тухай бүр олон нийтэд тайлбарлан таниулах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан. Тухайлбал, 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал” сэдвээр хэвлэлийн бага хурал хийж, төсвийн бодлогын суурь таамаглал, нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээний талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгч, асуултад хариулсан нь олон нийтэд төсвийн бодлогын суурь ойлголтыг бодитой хүргэхэд чиглэсэн чухал ажил болсон.



2025 оны 09 дүгээр сард 2026 оны төсвийн төсөл, дунд хугацааны төсөөлөлтэй холбоотой асуудлаар хэвлэлийн бага хурал хийж, төсвийн төлөвлөлтөд тусгасан гол чиг хандлага,

макро эдийн засгийн нөхцөл, төсвийн тогтвортой байдлын шалгуур, бодлогын эрсдэл, анхаарах асуудлуудын талаар олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарлан мэдээлсэн.

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хүсэлтээр зөвлөлийн дарга, гишүүд телевизийн ярилцлага, мэдээллийн сайтад өгсөн ярилцлага, нийтлэл, мэдээ мэдээллээр дамжуулан төсвийн сахилга бат, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн бодлого, төсвийн тусгай шаардлага, төсвийн орлого бүрдүүлэлт ба зарлагын бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чанар, төсвийн эрсдэлийн удирдлага зэрэг сэдвээр байр сууриа илэрхийлж, төсвийн бодлого, шийдвэрийн талаарх олон нийтийн ойлголт, хүлээлтийг бодитой болгоход чиглэсэн мэдээлэл өгсөн.

Зөвлөл нь олон нийттэй харилцах ажлын нэг хэсэг болгон хамтын ажиллагааны хүрээнд нээлттэй арга хэмжээ, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцож, төсвийн бодлогын асуудлыг олон талын оролцоотой хэлэлцүүлэх замаар мэдээллийн ил тод байдал, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.

Мөн Зөвлөлийн албан ёсны дүгнэлт, зөвлөмжүүдийг цахим орчинд нийтэд хүртээмжтэй байршуулах, мэдээллийн эх сурвалжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Зөвлөлийн холбогдох материалуудыг УИХ-ын цахим хуудсаар тухай бүр нийтэлж, хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээлэл бэлтгэх нөхцөлийг дэмжин ажиллалаа. Ингэснээр Зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал нэмэгдэж, төсвийн бодлогын асуудлаар олон нийтэд цаг тухайд нь үнэн зөв мэдээлэл хүргэх, төсвийн сахилга бат, тогтвортой байдлын талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан болно.

Хүснэгт 1. 2025 онд УИХ-ын цахим хуудсанд нийтлэгдсэн ТТБЗ-ийн дүгнэлт, мэдээллийн хандалтын тоо

№	Мэдээний огноо	Мэдээний нэр	Хандалтын тоо
1	2025.03.14	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал, 2026-2028	5,049
2	2025.03.31	ТТБЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан	810
3	2025.05.14	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд ТТБЗ-ээс өгсөн дүгнэлт	742
4	2025.05.14	2026-2028 оны Дунд хугацааны төсвийн мэдэгдэлд ТТБЗ-ийн дүгнэлт	1,015
5	2025.06.23	Монгол Улсын 2024 оны Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд өгсөн дүгнэлт	995
6	2025.06.23	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн дүгнэлт	760
7	2025.06.27	2025-2027, 2026-2028 оны Дунд хугацааны төсвийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ТТБЗ-ээс өгсөн дүгнэлт	796
8	2025.06.27	Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт	739
9	2025.07.07	Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаарх ТТБЗ-ийн байр суурь	801
10	2025.09.15	2026-2028 оны Дунд хугацааны төсвийн мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх ТТБЗ-ийн дүгнэлт	455

11	2025.09.15	Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгсөн ТТБЗ-ийн дүгнэлт	950
12	2025.10.24	Төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэх үед Төсвийн болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гарсан саналд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт	1,206
13	2025.11.07	Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналтай холбогдуулан ТТБЗ-өөс өгсөн дүгнэлт	930
Нийт			15,248

Эх сурвалж: www.parliament.mn (2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар)

4.6.Олон Улсын Валютын Сантай хамтран ажилласан байдал

ТТБЗ-ийн гишүүн Н.Ууганбаатар нь Олон улсын валютын сангийн Кавказ, Төв Ази, Монголын бүс нутгийн чадавх бэхжүүлэх төв (ССАМТАС)-өөс зохион байгуулсан Макро эдийн засаг, төсвийн бодлогын “Peer-to-Peer” хоёр дахь удаагийн уулзалт, сургалт-хэлэлцүүлэгт Монгол Улсыг төлөөлөн оролцсон. Тус арга хэмжээ нь 2025 оны 02 дугаар сарын 24–25-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы хотод зохион байгуулагдсан бөгөөд бүс нутгийн улс орнуудын Макро эдийн засаг, төсвийн бодлого хариуцсан байгууллагуудын төлөөлөл оролцож, төсвийн бодлогын чадавх, харилцан суралцах хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготойгоор зохион байгуулагдсан.

Уг уулзалт, сургалт-хэлэлцүүлгийн хүрээнд төсвийн тусгай шаардлага болон төсвийн дүрмийн хэрэгжилтийн туршлага, түүнийг хэрэгжүүлэхэд төсвийн институтын гүйцэтгэх үүрэг, төсвийн зөвлөлийн тогтолцооны олон улсын сайн туршлага, бүс нутгийн орнуудад хэрэгжүүлж буй хэлбэрүүд, мөн Макро эдийн засаг, төсвийн бодлогын загварчлалын аргачлал, төсвийн бодлогын тогтворжуулах үүрэг, төсвийн эрсдэлийг төсвийн хүрээний баримт бичигтэй уялдуулах асуудлуудад төвлөрөн хэлэлцсэн. Тухайлбал, төсвийн дүрмийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүхий эдийн экспортлогч орнуудад төсвийн дүрэм хэрэгжүүлэхэд тулгардаг сорилтууд, төсвийн зөвлөлийн институтын зохион байгуулалт, чиг үүргийн талаар Европ болон хөгжиж буй орнуудын жишиг туршлага, төсвийн бодлогын макро эдийн засагт үзүүлэх нөлөөг үнэлэх аргачлал, төсвийн бодлогын тогтворжуулах үүрэг, төсвийн эрсдэлийн удирдлагын асуудлуудыг хамруулсан.

Энэхүү Олон улсын арга хэмжээнд Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар оролцсоноор Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлага, төсвийн зөвлөлийн үндсэн чиг үүргийн талаар танилцуулж, бүс нутгийн улс орнуудын туршлагаас суралцах, өөрийн улсын туршлага, сургамжийг харилцан солилцох, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох бодит боломж бүрдсэн.

Түүнчлэн төсвийн дүрэм, төсвийн тогтворжуулах бодлого, төсвийн эрсдэлийн удирдлагын хүрээнд дунд хугацааны төсвийн төлөвлөлт, төсвийн сахилга бат, төсвийн бодлогын харилцаа холбоо, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой сайн туршлагуудыг тодорхойлсон. Мөн Олон улсын валютын сангаас Монгол Улсад ажилласан “Төсөв, мөнгөний бодлого, эдийн засгийн төсөөллийг шинэчлэх” зорилго бүхий ажлын хэсэгтэй 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр болон 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Зөвлөлийн зарим гишүүд уулзалт, ярилцлага хийж, макро эдийн засгийн орчин, төсвийн бодлогын өнөөгийн нөхцөл байдал, төсвийн эрсдэлийн асуудлаар мэдээлэл солилцож, холбогдох байр сууриа илэрхийлсэн.

4.7. УИХ-тай хамтран ажилласан байдал

УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийг УИХ-д өргөн мэдүүлэх, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхтэй холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаанд ТТБЗ мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх байгууллагын хувиар оролцож ажиллав. Тус ажлын хэсэг нь төсвийн баримт бичгүүдийг УИХ-д өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах үйл явцыг илүү нээлттэй, шат дараалалтай, үр дүнтэй болгох, төсөв хэлэлцэх хугацааны зохицуулалтыг боловсронгуй болгох, мөн төсөвт нөлөө үзүүлдэг хууль тогтоомжийн уялдааг сайжруулах зорилготойгоор санал, дүгнэлт боловсруулсан бөгөөд энэ хүрээнд ТТБЗ нь холбогдох хууль тогтоомжийн төсөлд зөвлөлийн чиг үүрэг, оролцоог илүү тодорхой болгож тусгах санал, байр суурийг хүргүүлсэн.

Ажлын хэсгийн хүрээнд төсвийн төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг шинэчлэх, төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх тусгайлсан дэгийг бий болгох, мөн ТТБЗ-ийн дүгнэлтийг УИХ-ын хэлэлцүүлгийн тодорхой үе шатанд заавал сонсож хэлэлцдэг байх эрх зүйн зохицуулалтыг тусгах чиглэлээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулсан. Тухайлбал, төсвийн төсөлтэй танилцах хэлэлцүүлэг нэртэй шинэ үе шатыг бий болгож, уг үе шатанд “ТТБЗ-ийн дарга төсвийн төсөл холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэх талаарх дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах” зохицуулалтыг тусгасан нь Зөвлөлийн дүгнэлтийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, УИХ-ын гишүүдийг мэргэжлийн мэдээллээр хангах, төсөв хэлэлцэх шийдвэр гаргалтыг нотолгоонд суурилсан болгох нөхцөлийг бүрдүүлэх чухал алхам болсон.

Мөн төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх үйл явцыг 4 үе шаттайгаар зохион байгуулж, эхний хэлэлцүүлэгт Ерөнхий сайдын илтгэлийн хамт ТТБЗ-ийн дүгнэлтийг сонсох, цаашдын хэлэлцүүлгүүдэд Байнгын хороодын санал, дүгнэлт, хамтарсан хуралдааны шийдвэртэй уялдуулан Зөвлөлийн дүгнэлтийг дахин авч үзэх зохицуулалтыг тусгах саналуудыг боловсруулсан. Үүний зэрэгцээ Засгийн газраас төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн төлөвлөгөө болон холбогдох бусад баримт бичгийг тодорхой хугацаанд ТТБЗ-д хүргүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагыг онцолж, ингэснээр Зөвлөл хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, шаардлагатай дүн шинжилгээ, дүгнэлт, санал боловсруулах бодит боломж бүрдэх нөхцөлийг тусгах чиглэлээр ажлын хэсэгт санал хүргүүлсэн.

Түүнчлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуульд төсөв хэлэлцэх хугацаа, үе шат нэмэгдсэнтэй уялдуулан Төрийн аудитын байгууллага болон ТТБЗ-ийн дүгнэлт гаргах хугацааг уялдуулан шинэчлэх шаардлагыг тусгаж, төсвийн төсөл хэлэлцэх үйл явцад Зөвлөлийн дүгнэлт цаг хугацааны хувьд үр нөлөөтэй ашиглагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажилласан. Мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах хүрээнд Төрийн аудитын байгууллагын аудитлагдсан Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд Зөвлөл дүгнэлт өгөх зохицуулалтыг өөрчилж, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт хийх чиглэл рүү төвлөрүүлэх саналыг тусгасан нь Зөвлөлийн чиг үүргийг илүү бодитой, үндсэн зорилгод нь нийцүүлэн тодорхойлох өөрчлөлт болсон.

4.8. УИХ-ын чуулганы хуралдаан, хэлэлцүүлэгт оролцсон байдал

ТТБЗ нь хуульд заасан чиг үүргийн хүрээнд УИХ-д өргөн мэдүүлсэн төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслүүдийг хэлэлцэх үе шатанд УИХ-ын холбогдох Байнгын хороод, ажлын хэсэг, Чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ажилласан.

Зөвлөлийн оролцоо нь төсвийн хэлэлцүүлгийг нотолгоонд суурилсан, мэргэжлийн түвшинд өрнүүлэх, төсвийн тусгай шаардлага, төсвийн тогтвортой байдлын шалгуур, макро эдийн засгийн суурь таамаглал болон төсвийн эрсдэлийн үнэлгээг УИХ-ын хэлэлцүүлгийн явцад бодитой тусгах зорилготой байв.

Энэ хүрээнд Зөвлөлийн дарга, гишүүд УИХ-ын төсөв, эдийн засаг, хөгжлийн бодлоготой холбоотой хэлэлцүүлгүүдэд хуваарийн дагуу оролцож, Зөвлөлийн гаргасан дүгнэлт, санал, зөвлөмжийн үндсэн агуулгыг танилцуулан, УИХ-ын гишүүдийн асуултад хариулж, холбогдох тооцоо, тайлбар мэдээллийг өгсөн. Мөн төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад төсвийн орлого бүрдүүлэлт, зарлагын бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, өрийн удирдлага, төсвийн сахилга бат, дунд хугацааны төсөөлөл, төсвийн тогтворжуулах бодлогын хэрэгжилт зэрэг асуудлыг онцлон хэлэлцүүлж, төсөв батлах шийдвэрийн чанарыг сайжруулахад чиглэсэн байр суурийг илэрхийлсэн.

Зөвлөлийн оролцоо нь зөвхөн нэг удаагийн хэлэлцүүлгээр хязгаарлагдахгүй, тухайн баримт бичгийг хэлэлцэх үе шат бүрд үргэлжилсэн бөгөөд төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, төсвийн тодотгол, төсвийн гүйцэтгэл болон хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэлэлцүүлгийн хугацаанд зөвлөлийн гишүүд хуваарийн дагуу холбогдох хуралдаанд тогтмол сууж, хэлэлцүүлгийн явцад гарсан санал, асуулт, анхаарах асуудлуудыг нэгтгэн авч үзэх, цаашдын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулахад ашигласан.

Ингэснээр 2025 онд Зөвлөл нь УИХ-тай харилцах чиг үүргээ бодитой хэрэгжүүлж, төсвийн бодлогын хэлэлцүүлгийн ил тод байдал, мэргэжлийн түвшин, бодлогын уялдаа, төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах асуудлыг хэлэлцүүлгийн төвд байлгах, мөн төсвийн бодлогын баримт бичгүүдийг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах чиглэлээр үр нөлөөтэй ажилласан гэж үзэж байна.

4.9. Засгийн газар болон бусад байгууллагатай хамтран ажилласан байдал

ТТБЗ нь 2025 онд хуульд заасан чиг үүргийн хүрээнд төсвийн бодлогын ил тод байдал, бодлогын уялдаа холбоог дэмжих, нотолгоонд суурилсан хэлэлцүүлгийг өргөжүүлэх зорилгоор төрийн захиргааны төв байгууллагууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхтэй өргөжүүлэн ажилласан. Энэ хүрээнд төсвийн бодлогын шинжилгээ, макро эдийн засгийн төлөв, төсвийн эрсдэлийн үнэлгээ, дунд хугацааны төсвийн хүрээ, хөрөнгө оруулалтын бодлогын асуудлаар мэдээлэл солилцох, санал зөвлөмж хүргүүлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэгт оролцох уулзалт, ярилцлагуудыг тогтмол зохион байгуулсан.

Үндэсний статистикийн хорооноос 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “ДНБ-ийг хэлхээ индекс ашиглан тооцоолох нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоолол, статистикийн аргачлалын шинэчлэл нь макро эдийн засгийн үнэлгээ, төсвийн таамаглал боловсруулахад үзүүлэх ач холбогдлын талаар хэлэлцэж, санал бодлоо хуваалцсан. Мөн Эдийн засаг, хөгжлийн болон Сангийн

сайд, холбогдох албан тушаалтнуудтай хийсэн уулзалтуудад оролцож, төсвийн бодлогын хэрэгжилт, тулгамдсан асуудал, цаашдын бодлогын чиглэлтэй холбоотой асуудлаар харилцан санал солилцсон.

ТТБЗ-ийн дарга, гишүүд 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учралтай уулзалт хийж, Монгол Улсын ирэх жилийн төсвийн төсөл болон ойрын таван жилийн хөгжлийн үндсэн чиглэлийг батлахтай холбоотой асуудлаар санал солилцов. Уулзалтын үеэр Зөвлөлийн зүгээс Засгийн газраас хэрэгжүүлэх



хөгжлийн төслүүдийн үнэлгээ, хэрэгжилтийн үр нөлөөг бодитой тодорхойлох, төсвийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийг эрт үе шатанд тооцож үнэлэх шаардлагатайг онцолж, мөн экспорт, импортын өсөлт, бууралтын үзүүлэлтийг бодит цагийн горимоор хянах, нээлттэй мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь

бодлого боловсруулах болон төсвийн эрсдэлийг удирдахад ач холбогдолтой болохыг тэмдэглэв. Түүнчлэн, эдгээр чиглэлээр шаардлагатай мэдээллийг Зөвлөлийн гишүүдэд тогтмол, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэхээр талууд тохиролцож, цаашид мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг тогтмолжуулах талаар санал нэгдэв.



Сангийн сайд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Зөвлөлийн гишүүдтэй уулзалт хийж, Монгол Улсын 2026 оны улсын төсвийн төслийн талаар танилцуулав. Уулзалтын үеэр 2026 оны төсөв нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлах, эдийн засаг дахь төрийн

оролцоог бууруулах замаар хувийн хэвшлийн өсөлтийг дэмжих чиглэлд төвлөрч буйг онцолсон. Мөн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд анхаарч, E-Mongolia системээр 188,016 иргэн санал өгсөн бөгөөд иргэдийн голлон илэрхийлсэн санал нь эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчний салбарт төсвийг түлхүү чиглүүлэх, төрийн байгууллагын төсвийн үр ашиг, сахилга батыг сайжруулах, татварын бодлогын уян хатан зохицуулалтыг нэмэгдүүлэх зэрэг байсныг онцолсон.

Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого нь “Хүний хөгжил - Мега төсөл” зорилтыг дэмжихэд чиглэж, боловсрол, эрүүл мэнд, цахим хөгжил, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр тусгагдсан байна.

Нээлттэй нийгэм форумаас 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан “Засгийн газрын болон нийслэлийн мега төслүүдийн зураглал” сэдэвт танилцуулах уулзалтад оролцож, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төслийн сонголт, эрэмбэлэлт, хэрэгжилтийн үр ашиг, төсвийн эрсдэлийн удирдлагын талаарх санал бодлоо илэрхийлсэн.

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-аас Эдийн засаг, хөгжлийн яаманд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх” төслийн танилцуулах уулзалтад оролцож, Монгол Улсын эдийн засаг дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн болон институтын зохицуулалтын хэрэгжилт, цаашид сайжруулах шаардлагатай чиглэлүүдийн талаар санал, байр сууриа илэрхийлсэн. Мөн Япон Улсаас Монгол Улсад олгох иений хөнгөлөлттэй зээлтэй холбоотойгоор JICA байгууллагаас ирсэн Монгол Улсын эдийн засгийн үнэлгээний багийн төлөөлөлтэй уулзалт хийж, улсын төсвийн нөхцөл байдал, төсвийн сахилга бат, зарлагын бүтэц, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тулгамдсан асуудлууд, дунд хугацааны төсвийн бодлогын хэрэгжилт, төсвийн эрсдэлийн үнэлгээтэй холбоотой асуудлаар мэдээлэл өгч, санал солилцсон нь Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд ач холбогдолтой болсон.

Дээрх уулзалт, харилцаа, хамтын ажиллагааны үр дүнд Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд төсвийн бодлогын асуудлыг олон талын оролцоотой хэлэлцэх, нотолгоонд суурилсан санал зөвлөмж хүргүүлэх, Олон улсын байгууллагуудын аргачлал, сайн туршлагыг судлан дүгнэлт, зөвлөмжийн чанарыг сайжруулах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

ТАВ. ДОТООД АЖИЛ

5.1.ТТБЗ-ийн үйл ажиллагааны журам

ТТБЗ нь 2025 оны үйл ажиллагааны хүрээнд өөрийн бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэх институтын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны дотоод удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн журмыг тогтоох зорилгоор “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Зөвлөлийн хуралдааны шийдвэрээр баталсан. Уг журам нь Зөвлөлийн бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Зөвлөл болон түүний Ажлын албаны үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг болж, Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаа, хуралдааны зохион байгуулалт, шийдвэр гаргалтын дэг, албажуулалт, тайлагнал, мэдээлэл түгээх үйл ажиллагааны нэгдсэн стандартыг тодорхой болгосон.

Журмаар Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тодорхойлж, тухайлбал, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн таамаглал боловсруулах, төсөв болон хууль, тогтоолын төслүүдэд дүгнэлт гаргах, төсвийн эрсдэл болон бодлогын нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд УИХ-ын чуулганы хуралдаанд оролцох, холбогдох Байнгын хороог мэдээлэл, тооцоогоор хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийг бодитой, үндэслэлтэй, мэргэжлийн мэдээллээр хангах зэрэг чиг үүргийг тусгасан. Мөн Зөвлөл үйл ажиллагаандаа хууль дээдлэх, мэргэжлийн

байх, шударга байх, улс төрийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг чанд баримтлан ажиллах зохицуулалтыг журамд тодорхой тусгасан.

Түүнчлэн журамд Зөвлөлийн хуралдааны үндсэн зохион байгуулалт, ээлжит болон ээлжит бус хуралдаан хуралдуулах нөхцөл, ирцийн шаардлага, асуудал хэлэлцэх дэг, санал хураалт, шийдвэр гаргалт, хуралдааны тэмдэглэл хөтлөлт, шийдвэрийг албажуулах, архивын нэгж болгон бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааны стандарт шаардлагыг нарийвчлан тогтоосон. Ингэснээр Зөвлөлийн шийдвэр гаргалт, баримтжуулалт, албажуулалт нь илүү эмх цэгцтэй, тогтвортой, нэгдсэн дэг журамтай болж, хуралдааны үр нөлөө, шийдвэрийн хэрэгжилтийг хангах нөхцөл сайжирсан.

Мөн журамд Зөвлөлийн Ажлын алба болон Судалгааны чиг үүрэг бүхий нэгжийн үйл ажиллагаа, гүйцэтгэх үүрэг, хариуцлага, Зөвлөлийн гишүүдтэй уялдах байдал, албан хаагчдын нийтлэг эрх, үүрэг, хориглох зүйлс, төсөв, санхүүгийн төлөвлөлт, тайлагналын зохицуулалтыг тусган тодорхойлсон. Үүний үр дүнд Зөвлөлийн институтын үйл ажиллагаа илүү зохион байгуулалттай, гүйцэтгэлд суурилсан хэлбэрт шилжих үндэс бүрдэж, Зөвлөлийн хуульд заасан чиг үүргийг тогтвортой хэрэгжүүлэх, олон нийтэд мэргэжлийн мэдээлэл хүргэх чадавхыг нэмэгдүүлэхэд бодит ахиц гарсан гэж үзэж байна.

5.2.ТТБЗ-ийг институтийн хувьд бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

ТТБЗ-ийн гишүүд 2025 онд хуульд заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлж гүйцэтгэх, төсвийн бодлогын дүн шинжилгээ, үнэлгээний чанарыг сайжруулах, Олон улсын аргачлал, сайн туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор мэргэжлийн ур чадвараа тогтмол сайжруулан ажилласан. Энэ хүрээнд Зөвлөлийн гишүүд Олон улсын сургалт, семинар, чадавх бэхжүүлэх хөтөлбөрүүдэд хамрагдаж, төсвийн төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээ, макро эдийн засгийн орчны үнэлгээ, төсвийн эрсдэлийн шинжилгээ, хөгжлийн бодлого болон төсвийн уялдаа холбоог сайжруулах арга зүй, тооцооллын практик хэрэглээний талаар мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн.

Зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл Олон Улсын Валютын Сангийн Санхүүгийн асуудлын газар (FAD)-аас 2025 оны 02 дугаар сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулсан “Дунд хугацааны төсвийн хүрээ” (Medium Term Fiscal Frameworks – MTFFs) сэдэвт сургалт, семинарт оролцож, дунд хугацааны төсвийн төлөвлөлт, төсвийн бодлогын зорилтыг дунд хугацаанд хангах тооцоолол, төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн уялдаа, төсвийн эрсдэлийн үнэлгээ, төсвийн бодлогын сахилга бат, тогтвортой байдлыг дэмжих бодлогын хэрэгсэл, үнэлгээний аргачлалын талаар туршлага судалсан.

Зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа Олон Улсын Валютын Сангаас 2025 оны 04 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Казакстан Улсын Алма-Аты хотод зохион байгуулагдсан “Тогтвортой хөгжлийн зорилгууд-Санхүүжилтийн хэрэгсэл” (Sustainable Development Goals – Financing Tool, SDG-FiT) сэдэвт сургалт, семинарт оролцож, тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэрэгцээг тооцоолох, хөгжлийн бодлого болон төсөв, санхүүгийн боломжийн уялдааг үнэлэх, санхүүжилтийн зөрүүг тодорхойлох, улмаар бодлогын өөр өөр хувилбарын үр нөлөөг тооцооллын үндэслэлтэйгээр үнэлэх аргачлалын талаар туршлага судалсан. Сургалтын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, авто зам, эрчим хүч, усан хангамж, ариун цэврийн үйлчилгээ зэрэг үндсэн салбаруудад шаардлагатай хөрөнгө оруулалтын хэрэгцээг тооцох аргачлал, үр дүнг төсөв, дунд хугацааны төлөвлөлттэй уялдуулах боломж, бодлогын шийдвэр гаргалтад ашиглах

арга зүйг судалсан нь Зөвлөлийн дүгнэлт, зөвлөмжийн чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон.

Зөвлөлийн гишүүн А.Энхбат Олон Улсын Валютын Сан болон Японы Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгждэг “JISPA” байгууллагын шугамаар Япон Улсын Киото хотод 2025 оны 04 дүгээр сарын 07-19-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Гадаад сектор болон валютын ханш” сэдэвт семинарт оролцож, төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа, гадаад секторын эрсдэлийн үнэлгээ, валютын ханшийн хэлбэлзлийн макро эдийн засаг болон төсвийн орчинд үзүүлэх нөлөөлөл, мөн эдгээр үзүүлэлтийг таамаглал, төсвийн бодлогын шинжилгээнд ашиглах аргачлалын талаар туршлага судалсан.

Мөн 2025 оны 12 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд НҮБХХ-өөс Улаанбаатар хотод зохион байгуулсан “Тогтвортой дэд бүтэц: арга хэрэгсэл, шинжилгээ ба хэрэгжүүлэх арга зам” сэдэвт сургалт, семинарт Зөвлөлийн гишүүн Н.Ууганбаатар, А.Энхбат нар оролцож, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тогтвортой дэд бүтцийн ач холбогдол, дэд бүтцийн төлөвлөлтөд системийн сэтгэлгээг ашиглах, уур амьсгалын эрсдэл болон эмзэг байдлын шинжилгээ хийх, тогтвортой төслүүдэд өртөг–үр ашгийн шинжилгээ хийх, мөн нотолгоонд суурилсан бодлогын мэдээллийг боловсруулах, холбогдох талуудад үр дүнтэй хүргэх арга зүйн талаар туршлага судалсан.

Эдгээр сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд хамрагдсанаар Зөвлөлийн гишүүд төсвийн бодлогын шинжилгээ, дунд хугацааны төсөөлөл боловсруулах, төсвийн тогтвортой байдлын эрсдэлийг үнэлэх, хөгжлийн бодлогын зорилтыг төсөв, санхүүгийн боломжтой бодитой уялдуулах чиглэлээр хийх дүгнэлт, зөвлөмжийн чанарыг сайжруулах нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

5.3.Судалгаа, эрдэм шинжилгээний ажил

ТТБЗ нь 2025 онд төсвийн бодлогын нотолгоонд суурилсан дүгнэлт, зөвлөмжийн чанарыг сайжруулах, төсвийн тогтвортой байдлын шинжилгээний суурь мэдээлэл, арга зүйг баяжуулах зорилгоор судалгаа, эрдэм шинжилгээний ажлуудыг хийсэн. Энэ хүрээнд Монгол Улсын төрөөс төсвийн орлого, зарлагын уялдааг хангаж буй байдал, төсвийн нийт орлого, зарлага, тэнцэл, улсын өр, зээлийн нөхцөл байдалд иж бүрэн шинжилгээ хийж, “Монгол Улсын төсвийн 1990–2024 оны төлөв байдал” сэдэвт судалгааг гүйцэтгэсэн.

Уг судалгааны тайланг боловсруулахдаа нэгдсэн төсвийн сүүлийн 35 жилийн тоон мэдээлэлд тулгуурлан улсын төсвийн нийт орлого, зарлага, тэнцлийн өөрчлөлт, төсвийн орлого бүрдүүлэлт ба зарлагын бүтэц, төсвийн алдагдлын динамик, улсын өрийн удирдлага, мөн төсвийн тогтвортой байдлыг хангах бодлогын чиглэл, шинэчлэлийн хэрэгцээг хамруулан системтэй дүн шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд төсвийн шинэчлэлийн хүрээнд тодорхой эерэг өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч төсвийн сахилга бат хангалтгүй, хариуцлагын тогтолцоо, хяналтын үр нөлөө сул, төсвийн зарлагын төлөвлөлтийг хөгжлийн бодлоготой бодитой уялдуулж, үндэслэлтэй төлөвлөж хэрэгжүүлэх түвшин хангалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай, үр дүнтэй зарцуулах асуудал бүрэн шийдэгдээгүй хэвээр байгааг онцлон дүгнэсэн. Иймд төсвийн шинэчлэлийг цаашид төсвийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах, төсвийг үр дүнд чиглүүлэн гүйцэтгэлд суурилан төлөвлөх, төсвийн зарлагын үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр илүү зоримог, бодитой арга хэмжээгээр хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн санал, зөвлөмжийг боловсруулсан.

Мөн Зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээний бүтээл, олон нийтэд түгээх судалгааны ажлыг тогтмол дэмжин ажилласан бөгөөд Зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа нь судлаач Р.Алтангэрэл, Д.Сүрэнчимэг, П.Бямбасүрэн нартай хамтран “Монгол Улсад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн туршлага, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг бэлтгэн, Asian Review of Public Administration сэтгүүлийн 2025 оны 04 дүгээр сарын дугаарт нийтлүүлж, Олон улсын эрдэм шинжилгээний түвшинд нийтийн хүртээл болгосон. Түүнчлэн тэрээр төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дэмжих, төсөв, санхүүгийн удирдлагын онол, практикийн мэдлэгийг нэгтгэн түгээх зорилгоор Удирдлагын академийн Төрийн удирдлагын тэнхимээс хариуцан боловсруулсан “Төрийн захиргаа” сурах бичгийн 9 дүгээр бүлэг болох “Төсөв, санхүүгийн удирдлага” бүлгийг проф. Б.Баясгалангийн хамтран боловсруулж, хэвлэлтэд хүлээлгэн өгсөн нь төсвийн бодлого, санхүүгийн удирдлагын сургалт, судалгааны суурь материалын чанарыг сайжруулахад бодит хувь нэмэр оруулсан болно.

МУИС, ШУТИС-ийн профессор, багш нар болон төрийн албан хаагчид зэрэг нийт 25 зохиогчид хамтран оролцсон төрийн бодлого боловсруулах онол, арга зүй, хэрэгжилтийн үнэлгээ, бодлогын шинжилгээ, ирээдүйн чиг хандлага зэрэг өргөн хүрээний 18 бүлэг сэдвийг багтаасан “Төрийн бодлого” сурах бичиг, номонд Зөвлөлийн гишүүн доктор (PhD), профессор А.Энхбат “Төрийн бодлогын зардал-үр ашгийн шинжилгээ” бүлгийг бичсэн. Энэхүү сурах бичиг нь зөвхөн их, дээд сургуулийн оюутнуудад төдийгүй төрийн бодлого, нийтийн удирдлагын салбарыг сонирхогч судлаач, бодлого боловсруулагчдад зориулсан бүтээл юм.

5.4.Зөвлөлийн хуралдаан

ТТБЗ нь 2025 онд хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд, Зөвлөлийн дүрэм болон 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн нийт 18 удаагийн хуралдаан зохион байгуулж, өдөр тутмын дотоод ажлын хүрээнд 5 удаагийн уулзалт, мэдээлэл сонсох 3 удаагийн дотоод сургалтыг тус тус зохион байгуулан ажиллав.

Зөвлөлийн 2025 оны хуралдаанаар макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал, Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах хуулийн төслүүд, мөн Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналтай холбогдуулан Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийн төсөл зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тухайлбал, 2025 оны 03 дугаар сарын 10, 14-ний өдрийн хуралдаанаар макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал болон 2026-2028 оны төлөвлөлттэй холбоотой асуудлыг хэлэлцсэн бол 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар ТТБЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн баталсан. Мөн 05 дугаар сарын 09, 12-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн төсөл болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төсөлд өгөх дүгнэлтийн төслийг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зөвлөл 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд ТТБЗ-өөс өгсөн дүгнэлтийн төслийг хэлэлцсэн бөгөөд 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгөх дүгнэлтийн төслийг хэлэлцсэн.

Түүнчлэн 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар төсвийн ерөнхийлөн захирагчдын 2026 оны төсвийн төсөл нь төсвийн хязгаарт нийцэж буй эсэх, олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан байдалд хийсэн дүн шинжилгээ, саналыг хэлэлцсэн бол 09 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд өгөх дүгнэлтийн төслийг хэлэлцсэн.

Мөн 10 дугаар сарын 20, 23-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарсан саналд өгөх ТТБЗ-ийн дүгнэлтийн төслийг хэлэлцсэн бөгөөд 11 дүгээр сарын 06, 20-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан саналтай холбогдуулан Зөвлөлөөс өгөх дүгнэлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Үүнээс гадна 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар Зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хэлэлцэн баталж, үйл ажиллагааны зохион байгуулалтын дотоод зохицуулалтыг бүрдүүлэн ажилласан болно.

ЗУРГАА. ХАВСРАЛТ

Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
төлөв байдлын таамаглал (2026–2028)



Монгол Улсын хөгжлийн 2026 оны
төлөвлөгөөний төсөлд өгсөн Төсвийн
тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт



Дунд хугацааны төсвийн хүрээний
мэдэгдэл (2026–2028)-д өгсөн Төсвийн
тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт



Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн
гүйцэтгэлд өгсөн Төсвийн тогтвортой
байдлын зөвлөлийн дүгнэлт



Монгол Улсын Засгийн газрын 2024 оны
санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн
Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн
дүгнэлт



2025–2028 оны Төсвийн хүрээний
мэдэгдэлд оруулах тухай хуулийн төсөлд
өгсөн Төсвийн тогтвортой байдлын
зөвлөлийн дүгнэлт



Монгол Улсын 2025 оны Төсвийн
тодотголын төсөлд өгсөн Төсвийн
тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт



2026–2028 оны Төсвийн хүрээний
мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөлд өгсөн Төсвийн
тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт



2026 оны төсвийн төслийн боловсруулалт
дахь төсвийн хязгаар ба олон нийтийн
оролцооны талаар Төсвийн тогтвортой
байдлын зөвлөлийн дүгнэлт



Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд
өгсөн Төсвийн тогтвортой байдлын
зөвлөлийн дүгнэлт



2026–2028 оны Төсвийн хүрээний
мэдэгдлийн 2 дахь хэлэлцүүлгээс гарсан
саналд өгсөн Төсвийн тогтвортой
байдлын зөвлөлийн дүгнэлт



Монгол Улсын 2026 оны Төсвийн
төслийн гурав дахь хэлэлцүүлгийн явцад
гаргасан саналуудын талаарх Төсвийн
тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт



Төсвийн тогтвортой байдлын тухай
хуульд нэмэлт оруулах асуудлаарх байр
суурь

